Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 он

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (тайлбар) | Гүйцэтгэлийн хувь | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БОДИТ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛНЭ** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилт 1.1. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулсан байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.1.1 Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, санал хүргүүлэх ажлыг зохион байгуулах, боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх** | | **Улсын төсөв** | **Шинэчлэн болон шинээр батлуулсан баримт бичгийн тоо** | **-** | **3** | **5** | **"Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам", "Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих нийтлэг журам", "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам" боловсруулах зэрэг 8 чиглэлийн хүрээнд 11 ажил төлөвлөсөн.** | | |
| 1.1.1.1 | "Хяналт-шинжилгээ хийх журам"-ыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах | Улсын төсөв | Батлуулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын төсөлд 16 яамны **60**, 15 агентлагийн **9**, аймаг нийслэлээс ирүүлсэн 75, нэмэлт 55 саналыг нэгтгэн, холбогдох саналыг тусгаж Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 | 100 |
| 1.1.1.2 | Үнэлгээ хийх журам"-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах | Улсын төсөв | Батлуулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | "Үнэлгээ хийх журам"-ын төсөлд 16 яамны **76**, 15 агентлаг, 21 аймаг, нийслэлээс ирүүлсэн **32** саналыг нэгтгэн холбогдох саналыг тусгаж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 | 100 |
| 1.1.1.3 | "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх | Улсын төсөв | Батлуулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын төсөлд 16 яамны **87**, 15 агентлаг, аймаг, нийслэлээс ирүүлсэн **51** саналыг нэгтгэн холбогдох саналыг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | журам"-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах | | | | | | тусгаж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлуулсан. | | |
| 1.1.1.4 | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих нийтлэг журам"-ын төслийг боловсруулж, батлуулахаар санал хүргүүлэх | Улсын төсөв | Боловсруулж, хүргүүлсэн санал (тоо) | - | - | 1 | -"Хяналт тавих нийтлэг журам"-ыг боловсруулахад зохион байгуулсан хэлэлцүүлэг, санал солилцох уулзалтын явцад алба хаагчдаас гаргасан 57 саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан "Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт хийх нийтлэг журам"-ыг боловсруулах ажлын хэсэг нийт 3 удаа хуралдан журмын төслийг боловсруулж, ЗГХХГ-ын дотоод нэгжүүд, 2025 оны 04 дүгээр сард ЗГ-ын гишүүдээс саналыг авч журмын эцсийн хувилбарыг бэлэн болгон ЗГХЭГ-т хүргүүлэхэд бэлэн болгоод байна.<br>Журмын төслийн танилцуулга 80%,<br>Журмын саналын товьёог 70%,<br>Журмын төслийн эцсийн хувилбар 70%-тай байна.<br>-"ЗГХХГ-ын ерөнхий хянан шалгагч, ахлах хянан шалгагч, хянан шалгагчийн нэмэгдэл олгох журам"-ыг боловсруулж батлуулсан. Хяналт тавих нийтлэг журам, Албан тушаалын тодорхойлолт, Хяналт шалгалтын нэгдсэн системийн хөгжүүлэлт, Байгууллагын стратеги төлөвлөгөө, Хөдөлмөрийн дотоод журмын төслүүдэд нийт 96 санал хүргүүлсэн. | 100 | 70 |
| 1.1.1.5 | "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын төсөл, тайлангийн маягтыг боловсруулж, батлуулах | Улсын төсөв | Боловсруулж, батлуулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын А/75 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>-Журмын төслийг боловсруулж, ажлын хэсгийн хүрээнд хоёр удаа хэлэлцүүлэн, гишүүдийн санал, зөвлөмжийг тусган, төслийг олон нийтээр хэлэлцүүлэн, санал авахаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим хуудас (https://ags.gov.mn/-нд)-т 2025 оны 07-р сарын 18-ны өдрөөс хойш байршуулан ажилласан.<br>-Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын өргөдөл, гомдол, хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 албан хаагчийг оролцуулан 3 удаагийн хэлэлцүүлгийг 2024 оны 9 сарын 24-25-ны өдрүүдэд цахимаар (zoom meeting) зохион байгуулж, гарсан саналыг тусган, журмын нөлөөллийн шинжилгээг боловсруулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Хүний эрх ба төрийн бүтээмжийн хамтарсан сургалтын хүрээнд яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг Дарга, удирдах албан тушаалтнуудад тус журмын төслийн танилцуулгыг хийсэн.<br>-"Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн, засаг хөгжлийн сайдын 2025.11.17-ны өдрийн А/66 дугаар тушаалаар батлуулсан.<br>-Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд албан бичиг, холбогдох тайлангийн хамт хүргүүлсэн.<br>Журам батлагдсантай холбогдуулан журмын зохицуулах харилцаа, өргөдөл, гомдлын талаарх тайлан, мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх, хүргүүлэхтэй холбоотой зохицуулалтыг танилцуулах цахим сургалт явуулах бэлтгэлийг ханган, яам, агентлаг, орон нутгийн ЗДТГ-т зохион байгуулсан. | | |
| 1.1.1.6 | Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, бусад байгууллагатай хамтран ажиллах, сургалт зөвлөгөөн зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээний биелэлт хувь | - | 50 | 100 | ХҮЭК, НЗДТГ, Монгол Хуульчдын Холбоотой байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөг хуваарийн дагуу хэрэгжүүлж ажилласан.<br>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг судлах хүрээнд ИБУИНХУ, АНУ, Эстони зэрэг гадаад орнуудын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, Монгол Улс дахь төрийн хяналт шалгалтын өнөөгийн эрх зүйн орчин, хяналт шалгалтын төрөл, хэлбэр, хамрах хүрээ, хяналт шалгалт хэрэгжүүлж буй субъект, тэдгээрийн удирдлагын тогтолцоо зэргийг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, дүгнэлт боловсруулж, танилцуулга бэлтгэсэн.<br>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг судлах хүрээнд ИБУИНХУ, АНУ, Эстони зэрэг гадаад орнуудын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, Монгол Улс дахь төрийн хяналт шалгалтын өнөөгийн эрх зүйн орчин, хяналт шалгалтын төрөл, хэлбэр, хамрах хүрээ, хяналт шалгалт хэрэгжүүлж буй субъект, тэдгээрийн удирдлагын тогтолцоо зэргийг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, дүгнэлт боловсруулсан.<br>УИХ-ын ажлын хэсгийн гишүүдэд үзэл баримтлалын шалгуур болон холбогдох судалгааг танилцуулж хүлээлгэн өгсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | - | 70 | 100 | ХЭҮК-той 2 удаагийн уулзалт зохион байгуулж хамтран ажиллах төлөвлөгөө 2025.04.23-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.ЗГХХГ-т байгаа мэдээллүүдээс төрийн байгууллагын өргөдөл гомдлын мэдээллийг ХЭҮК-т хүргүүлсэн.<br>2.ХЭҮК-той хамтран зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулсан.<br>3.Сүүлийн 2 жилийн хугацаанд Төрийн байгууллагад хандан ХЭҮК-ын гишүүдээс гаргасан шаардлага, зөвлөмжийн тоо, мэдээллийг авсан.<br>4.2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр "Хүний эрх ба төрийн бүтээмж" сэдэвт сургалтыг Хүний эрхийн комисстой хамтран зохион байгуулсан. Уг сургалтад ХЭҮК, ЗГХХГ, НЗДТГ, нийслэлийн Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Налайх, Багануур, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт 45 албан хаагч хамрагдсан. Сургалтын үеэр "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээ гаргах, хүргүүлэх журам"-ын төсөл, "Иргэдээс Нийслэл Улаанбаатар хотын харьяа 9 дүүргийн төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан 2024 оны өргөдөл, гомдол ба нэгээс дөрвөн хүртэлх жил үргэлжилж байгаа хүний эрхийн зөрчил", төрийн байгууллагад хэрэгжүүлсэн Процессын дахин инженерчлэлийн судалгааны арга, аргачлал, олж мэдсэн туршлагын талаар мэдээлэл өгч, "Хүний эрхэд суурилсан хянан шалгах ажиллагаа", "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах нь", "Хүний эрхийн зөрчил ба гомдол шийдвэрлэх ажиллагаа", "Ажлын байрны дарамт, хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох нь" сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. | 100 | 70 |
| | | Улсын төсөв | Арга хэмжээний биелэлт хувь | - | 60 | 100 | НЗДТГ-тай хамтран ажиллах төлөвлөгөө 2025.04.04-ний өдөр баталсан.<br>Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор нийслэлээс үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг НЗДТГ-тай хамтран гүйцэтгэж байна. 2025.06.02-ны өдрөөс эхлэн цахим асуумжийн судалгааг эхлүүлсэн. Мөн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад ирсэн гомдолд шинжилгээ хийх ажил хийгдэж дууссан.<br>Хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1.Иргэн, аж ахуйн нэгжээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад 2022-2024-оны хооронд ирүүлсэн дата, мэдээллийг НЗДТГ-аас хүлээн авч нийт 103,046 өргөдөл, гомдлын дата мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулсан.<br>2.2025.06.02-07.09-ний өдрийн хооронд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын иргэдтэй харилцаж, үйлчилгээ үзүүлдэг 20 байгууллагын анхан шатны нэгжийн нийт **2304** албан хаагчдаас цахим судалгааг авч үр дүнд дүн шинжилгээ хийж, дашбоард хийж гүйцэтгэн тайлан боловсруулсан.<br>3.2025.06.02-07.09-ний өдрийн хооронд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас төрийн үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээдээс цахимаар сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд тус судалгаанд нийт 20 байгууллагаас үйлчилгээ авсан **1327** иргэн, **162** хуулийн этгээд хамрагдсан бөгөөд судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, дашбоард хийж гүйцэтгэн тайлан боловсруулсан.<br>4.Иргэдээс авсан цахим судалгаанд хамрагдсан иргэдээс үйлчилгээ бүрэн авч чадаагүй гэж хариулсан 42 иргэнээс цахим судалгааны үр дүнг бататгах, үйлчилгээ бүрэн авч чадаагүйгээс үүдэн дахин үйлчилгээ авахаар очсон давтамж, зарцуулсан хугацааг тодруулах 2025.09.29-10.02-ны өдрийн хооронд чанарын судалгаа авсан бөгөөд үр дүнд дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулсан. Нийт гурван судалгааны үр дүнг нэгтгэн шинжилсний үндсэн дээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээний явцад үүсэж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг илрүүлж, сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан, судалгааны тайланг боловсруулж гүйцэтгэлээ.<br><br>"Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлгийн үр дүнд:<br>-Газар эзэмших, ашиглахтай холбоотой 27 төрлийн хүсэлтийг цахим системээр хүлээн авч, шийдвэрлэх боломж бүрдэв;<br>-Иргэн, хуулийн этгээдээс шаарддаг 15 гаруй төрлийн мэдээллийг иргэдээс дахин шаардахгүй байхаар болов;<br>-Газартай холбоотой 40 гаруй үйлчилгээг цахим үйлчилгээний нэгдсэн портал болон киоск төхөөрөмжөөр дамжуулан авах боломжтой болов; | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой харилцааг хуульд байхгүй зохицуулалтаар буюу ажлын хэсгээр шийдвэрлэдэг тогтолцоог өөрчилж, шууд цахимаар шийдвэрлэх, шат дамжлагыг багасгаж шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэв;<br>-Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхийн харилцааг хуулийн хугацаанд шийдвэрлэх боломж бүрдэв;<br>-Төрийн байгууллага хооронд газартай холбоотой мэдээлэл солилцох ажиллагааг цахимаар бүрдүүлэх, солилцох, баталгаажуулах боломжууд бүрдэж байна. | | |
| | | Улсын төсөв | Арга хэмжээний биелэлт хувь | - | 70 | 100 | Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд судалгаа шинжилгээ хийх, холбогдох сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах чиглэлээр МХХ-той хамтран ажиллах санамж бичгийг 2025.01.20-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд ЗГХХГ, БОУАӨЯ, ХББОСЯ, ГЗБГЗЗЕГ, НЗДТГ, ШШГЕГ, МХХ зэрэг байгууллагуудын 80 гаруй албан хаагчдын төлөөлөл оролцож 2025.02.26-ны өдөр "Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Мөн санамж бичгийн хүрээнд 2025.05.28-ны өдөр "Дүрэм, журам боловсруулах арга зүй", "Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт", "Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" сэдэвт сургалт зохион байгуулагдаж ЗГХХГ-ын 50 гаруй албан хаагч нар хамрагдсан. | 100 | 100 |
| 1.1.1.7 | Нийгэм, эдийн засгийн бодлого, эрх зүйн зохицуулалт болон төрийн бүтээмж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах | Улсын төсөв | Судалгааны тайлан (тоо) | - | | 11 | Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал болон бодлого эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд удирдлагаас өгсөн чиглэл болон бодлогын баримт бичгүүд, өргөдөл, гомдлын агуулгатай уялдсан байдлаар судалгааны чиглэлийг гарган, байгууллага дахь нэгжээс санал авч эрэмбэлэн, газрын даргын 2025 оны 03 сарын 12-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар 11 судалгааны чиглэлийг батлуулсан. Багууд судалгааны удирдамж, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган, холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, гадаад улс орны туршлага, улсын болон олон улсын түвшний цаашдын чиг хандлагыг судлахаас гадна төрийн байгууллага, судалгааны хүрээлэнгийн байр суурийг тандах зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр тандалт судалгаа | 80 | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон, судалгааны явцыг тодорхой давтамжтайгаар танилцуулж ажилласан. Тухайлбал:<br>-Эрчим хүчний үнэ, Эмийн чанар, үнэ, Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмийн лабораторийн хүчин чадал, чадамж, Тэрбум мод, Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, ажлын ачаалал, стрессийн түвшинтэй холбоотой судалгааны өнөөгийн нөхцөлд байдалд хийсэн тандалт судалгааны үр дүнг байгууллагын удирдлага болон холбогдох газруудад танилцуулсан. Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, ажлын ачаалал, стрессийн түвшинтэй холбоотой судалгааны хүрээнд хийсэн хэлэлцүүлгийн үр дүнд ТАЗ, ЗГХЭГ, УА-тай хамтран ажиллах шийдэлд хүрч, ажлын хэсэг байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>-Хэвлэл мэдээллийн контент анализ хийх хүрээнд тухайн чиглэлээр ажилладаг 2 хувийн байгууллагатай уулзаж ажлын цар хүрээ, үнийн санал авч, байгууллагын болон нэгжийн удирдлагад танилцуулсан ба төсөв, санхүүгийн хэмнэлттэй холбоотойгоор тус судалгааг хийх боломжгүй болсон.<br>-Засгийн газрын харьяа байгууллагуудын чиг үүргийн давхардлыг тодорхойлох судалгааны хүрээнд судлагдсан байдалд баримтын судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.2.3.1-ийг үндэслэн төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, оновчлох хүрээнд нийтлэг чиг үүрэгт нэгдсэн байдлаар Чиг үүргийн шинжилгээ хийх саналыг дэвшүүлсэн. Үүний дагуу ЗГХЭГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 123 дугаар тушаалаар Засгийн газрын харьяа байгууллагуудын чиг үүргийн давхардлыг тодорхойлох чиглэлээр ТАЗ, ЗГХЭГ, ЗГХХГ-ын хамтарсан ажлын хэсгийг байгуулан, Засгийн газрын харьяа байгууллагуудын нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжид шинжилгээ хийхээр арга зүй, аргачлалыг боловсруулан, мэргэшсэн зөвлөх, судлаачдаас арга зүйн дэмжлэг авах сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллаж байна. | | |
| 1.1.1.8 | Хяналт шалгалтын үр дүнд үндэслэн хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журам, | Улсын төсөв | Санал, зөвлөмжийн тоо | 5 | 5 | 10 | Засгийн газрын 2012 оны "Хилийн заагийг тогтоох тухай" 194 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийг шинэчлэн батлуулах асуудлыг судлуулахаар АҮЭБЯ, БОУАӨЯ-дад албан бичгээр санал хүргүүлсэн. УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолын | 100 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж хүргүүлэх | | | | | | хавсралтаар батлагдсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын эхний үе шатанд хэрэгжих төсөл арга хэмжээг эрчимжүүлэх, үр ашиг, үр нөлөөнд тулгуурлаж хэрэгжүүлэх хугацааг оновчтой тодорхойлоход алба хаагчдаас санал авч нэгтгэн хүргүүлсэн. | | |
| **Стратегийн зорилт 1.2 Үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн тогтолцоог нэвтрүүлсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.1 Олон улсын үнэлгээний цогц систем (Design, Monitoring & Evaluation) -ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах** | | **Улсын төсөв, гадаадын зээл тусламж** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **-** | **85** | **Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 18-ний өдрийн А/49, А/18, 77 дугаар "Төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаал батлуулсан. Тус ажлын хэсэг "Олон улсын үнэлгээний цогц систем (DME)"-ийг нэвтрүүлэх бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.** | 81,3 | |
| 1.2.1.1 | Олон улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг хөгжүүлэх бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | | 85 | "Олон улсын үнэлгээний цогц систем (DME)"-ийн танилцуулга, түүний хавсралтаар уг системийг нэвтрүүлэх бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулж, тус хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасан байна.<br>Үүний дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 18-ний өдрийн А/49, А/18, 77 дугаар "Төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаал батлуулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтэд туссан нийт 37 арга хэмжээ 44 хувьтай хэрэгжсэн. | 44 | 44 |
| 1.2.1.2 | Олон Улсын үнэлгээний цогц систем (DME)-ийн ажлын даалгавар боловсруулж, батлуулах | Улсын төсөв | Батлуулсан ажлын даалгаврын тоо | - | 1 | 1 | Олон улсын үнэлгээний цогц систем (DME)-ийн ажлын даалгавар боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЗГХХГ-ын даргын 5 сарын 27-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, ажлын хэсгийн ахлагч гишүүдэд ажил үүргийг хуваарилсан бөгөөд ЭЗХЯ-наас хөгжлийн бодлого төлөвлөлтийн техникийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даалгавар/ажлын даалгавар боловсруулж ЗГХХГ-ын 2025.06.06 өдрийн 01/678 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т, хувийг ЦХИХХЯ, Ухаалаг Засаг-2 төсөлд хүргүүлсэн. | | |
| 1.2.1.3 | Олон Улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг олох | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | Олсон эх үүсвэрийн шаардлагатай санхүүжилтэд эзлэх хувь | - | 10 | 10 | "Ухаалаг засаглал 2" төсөлд олон улсын үнэлгээний цогц системийг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлүүлэхээр төслийн танилцуулга, шаардлагатай санхүүжилтийг тоймлон гаргаж 2025.02.05-ны өдөр хүргүүлсэн.<br>ЗГХЭГ болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад Олон Улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг нэвтрүүлэхэд гадаад улсын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тус тус хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан 7090-MN дугаартай санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу "Ухаалаг засаг-2" төслийн Удирдах хорооны 2025 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт болох 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 750,000 (долоон зуун тавин мянган) ам.долларын төсөв бүхий 2.1.14.1. Олон улсын үнэлгээний систем (DME) нэвтрүүлэх ажил батлагдсан ба ЗГХХГ-ын 2025.06.06 өдрийн 01/678 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т, хувийг ЦХИХХЯ, Ухаалаг Засаг-2 төсөлд энэхүү ажлын Техникийн тодорхойлолтыг хүргүүлэн ажилласан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.2 Үндэсний болон салбарын бодлогод үнэлгээ хийх** | | Улсын төсөв | **Хөндлөнгийн болон дотоод үнэлгээний тайлангийн тоо** | - | **1** | **1** | **"Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс (INCE)"-ийн үр дүнг танилцуулах үндэсний чуулганыг 400 гаруй оролцогчтойгоор 2025 оны 5 сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус индексийн үнэлгээгээр нийт 10 оноонoос 4.4 оноогоор үнэлэгдсэн байна.** | **65** | |
| 1.2.2.1 | Монгол Улсын хөгжлийн бодлогод үнэлгээ хийх | Улсын төсөв | Үнэлгээний тайлангийн тоо | - | - | 1 | ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллага (Deval)-тай хамтран "Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн бодлогод үнэлгээ хийх" ажлыг эхлүүлээд байна. Энэхүү ажлын хүрээнд ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллага (Deval) хамтран ажлын даалгаврыг батлуулж, үнэлгээний багт ажиллах багийн ахлагч болон үнэлгээчнийг тендерээр шалгаруулсан. Мөн ажлын даалгаврын дагуу 2026 онд хийх ажлын нарийвчилсан ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. | 30 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2.2 | Улсын үнэлгээний чадавхын индексийг тогтоох үнэлгээ хийх | Улсын төсөв | Үнэлгээний тайлангийн тоо | - | 1 | 1 | Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс (INCE)-ийг тогтоолгохоор, үнэлгээг цаашид хөгжүүлэх чиглэлээр зөвлөмж авахаар ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллага (DEVal)-тай хамтран Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал, тэдгээрийн харьяа байгууллага, Засгийн газар, яам, агентлаг, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит компани, их, дээд сургууль, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, судалгаа, үнэлгээний компани зэрэг нийт 164 байгууллагыг оролцуулан Улсын үнэлгээний чадавхын индекс болон индекс тогтоох асуумжийг хэрхэн бөглөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх цахим сургалтыг 3 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад ЗГХХГ-ын ҮМГ-ын дарга Д.Үүрийнтуяа, ахлах референт М.Баярмаа, ХБНГУ-ын Хөгжлийн Үнэлгээний институтийн үнэлгээний ажилтан Сабина Палмройтер, үнэлгээний ажилтан Хуан Карлос Санц, Монголын Үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч Ө.Эрдэнэчимэг, ТУЗ-ын дарга Г.Ууганцэцэг нар сургалт, танилцуулгыг хийж, төрийн болон хувийн байгууллагын 730 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. Монгол Улсын үнэлгээний чадавхын индексийг тооцож тогтоох судалгаа 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлж 4 дүгээр сарын 15-ны өдөр дууссан. Тус үнэлгээний үр дүнг "Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс (INCE)"-ийн үр дүнг танилцуулах үндэсний чуулганыг 400 гаруй оролцогчтойгоор 2025 оны 5 сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус индексийн үнэлгээгээр нийт 10 онооноос 4.4 оноо авч үнэлэгдсэн байна. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.3 Шийдвэр гаргалтад үнэлгээ, мониторингийн үр дүнг ашиглах механизм бий болгох хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тодорхойлж танилцуулах** | | **Үнэлгээ, мони Улсын төсөв** | **Үнэлгээ, мониторингийн үр дүнд үндэслэн гарсан шийдвэр** | - | - | 6 | **Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайланг Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 6 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээний тайланг Засгийн газрын 2025.05.28 өдрийн хуралдаанд танилцуулж, 25 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан** | 97.6 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3.1 | "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 1 | - | 1 | Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, тайлан, танилцуулга боловсруулан удирдлагад танилцуулахад бэлэн болсон. Хэрэгжилт 80 хувьтай. | 80 | 80 |
| 1.2.3.2 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 1 | 2 | 2 | <u>*2024 оны жилийн эцэс*</u><br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг ЭЗХЯ болон төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн нэгтгэн гаргаж, үнэлгээ хийсэн. ХШҮ-ний нэгдсэн тайлан, танилцуулга, бусад мэдээллийг эцэслэн боловсруулж, ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарсан.<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжжилгээ, үнэлгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, ЗГХЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллийг бэлтгэн ЗГХЭГ-т 2025 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 01/276 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн уг асуудлыг УИХ-ын Байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээллийг бэлтгэж хамтран ажилласан.<br><u>*2025 оны эхний хагас*</u><br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг үндэслэн "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, тайлан, холбогдох бусад мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэв. Уг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Засгийн газрын 2025.09.10-ны өдрийн хуралдаанд танилцуулж, УИХ-д танилцуулахаар хүргүүлсэн. | 100 | 100 |
| 1.2.3.3 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 1 | 1 | 1 | <u>*2024 оны жилийн эцэс*</u><br>Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг ЭЗХЯ болон төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргаж, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | | | | | | үнэлгээ хийсэн. ХШҮ-ний нэгдсэн тайлан, танилцуулга, бусад мэдээллийг эцэслэн боловсруулж, ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 6 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан.<br>Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, ЗГХЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллийг бэлтгэн ЗГХЭГ-т 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/276 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн уг асуудлыг УИХ-ын Байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллийг бэлтгэсэн.<br>*2025 оны эхний хагас*<br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусгавар болохоос дөрвөн сарын өмнө хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна" гэж заасныг үндэслэж 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг үнэлж, Засгийн газрын 2025.09.10-ны өдрийн 16 дугаар хуралдаанд танилцуулж, ЗГХЭГ-ын 2025.09.11-нихй өдрийн ЗГ-01/103 дугаар албан бичгээр УИХ-руу хүргүүлсэн. Улсын Их Хурлын даргын 2025 оны арван нэгдүгээр сарын 18-ны өдрийн захирамжаар байгуулсан ажлын хэсгийн гишүүдэд 2025.11.25-ны өдөр танилцуулсан. | | |
| 1.2.3.4 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 2 | 2 | 2 | *2024 оны жилийн эцэс*<br>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бодлого, 16 чиглэл, 620 зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. ХШҮ-ний нэгдсэн тайлан, танилцуулга, бусад мэдээллийг эцэслэн боловсруулж, ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарсан.<br>Засгийн газрын 2024-2028 оны гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УИХ-ын Тамгын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, ЗГХЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллийг бэлтгэн албан бичгээр хүргүүлсэн. Мөн уг асуудлыг УИХ-ын Байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд оролцсон.<br>*2025 оны эхний хагас* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 16 бодлогын үр дүнг хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшинг үнэлэх, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2 дугаар хавсралтаар батлагдсан ТЕЗ-ын 73 үр дүн болон 1 дүгээр хавсралтаар батлагдсан 1234 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, тайланг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулан холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна. | | |
| 1.2.3.5 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд газар дээрх хяналт хийх | Улсын төсөв | Хяналт хийсэн байгууллагын тоо | - | - | 16 | ЗГХХГ-ын даргын 2025.11.10-ны өдрийн "Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад газар дээр нь хянан үзэж, түүний гүйцэтгэлийн тайланг газар дээр нь хянан үзэж, дүн шинжилгээ хийх" 01/26 дугаар удирдамжийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 218 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгээр 16 яамны "үр дүнгүй" үнэлэгдсэн нийт **861** төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой шийдвэр, холбогдох баримт бичиг, цахим систем, мэдээлэлтэй зайнаас болон газар дээр нь очиж танилцаж, тухайн ажлыг хариуцсан нэгжийн удирдлага, албан хаагч, тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх оролцогч талуудтай уулзалт, ярилцлага хийж, тайлбар мэдээллийг нотлох баримтаар гаргуулан авч, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн бөгөөд тус удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын үр дүнг нэгтгэн тайлан, танилцуулга боловсруулахаар ажиллаж байна. | 80 | 80 |
| 1.2.3.6 | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 2 | 2 | 2 | *2024 оны жилийнн эцэс*<br>Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг ЭЗХЯ болон төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тодорхойлж үнэлсэн. ХШҮ-ний нэгдсэн тайлан, танилцуулга, холбогдох мэдээллийг эцэслэн бэлтгэж, ЗГХЭГ-т хүргүүлэн Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, тухайн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллүүдийг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/190, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/206, УИХ-ын Тамгын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/197 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн уг асуудлыг УИХ-ын Байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд ажлын хэсэгт ажилласан.<br>*2025 оны эхний хагас*<br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хэрэгжилтийн түвшин, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин, санхүүжилтийн гүйцэтгэлийг тодорхойлж, нэгдсэн тайлан, танилцуулга, холбогдох мэдээллийг эцэслэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгсөн. | | |
| 1.2.3.7 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний тайлангийн тоо | 2 | 2 | 2 | *2024 оны жилийн эцэс*<br>Монгол Улсын Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д бүртгэгдсэн нийт **1080** хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн **4369** (давхардсан тоогоор **14678**) заалтын хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 8.5-д заасан чиг үүргийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан, танилцуулга боловсруулж, УИХ-ын болон УИХ-ын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Ерөнхийлөгчийн шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тус тус бэлтгэн, ЗГХЭГ-т 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01/134 тоот албан бичгээр хүргүүлж, файлаар болон цаасаар хэвлэж | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бэлтгэн хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба УИХ-ын Байнгын хороодоор хэлэлцүүлэхэд ажлын хэсэгт ажилласан.<br>*2025 оны эхний хагас*<br>Монгол Улсын Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д бүртгэгдсэн нийт **1027** хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн **3839** (давхардсан тоогоор **14206**) заалтын хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шийдвэрийн төсөл, тайлан танилцуулга бэлтгэн ЗГХЭГ-т хүргүүлэн Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тайланг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан болон УИХ-ын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх ажлын хэсэгт орж, танилцуулсан. | | |
| 1.2.3.8 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | - | 1 | 1 | Сангийн яамнаас Монгол Улсын Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн нийт 135 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан ирүүлснийг хянан үзэж, нэгдсэн тайланг боловсруулж, удирдлагад танилцуулан, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын 4 дүгээр сарын 30-ны өдрийн 01/308 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Тайланг Засгийн газрын хуралд танилцуулахтай холбоотой шийдвэрийн төсөл танилцуулга бэлтгэж, удирдлагад танилцуулсан ба Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, тус өдрийн 25 дугаар тэмдэглэл гарсан.<br>Хуралдаанд танилцуулсан тайлан болон зөвлөмжийг ЗГХХГ-ын 2025.06.25-ны өдрийн 01/726 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 | 100 |
| 1.2.3.9 | Аймаг, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний нэгдсэн тайлангийн тоо | - | 1 | 1 | 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэн аймаг, нийслэл тус бүрээр болон нэгдсэн тайлан боловсруулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт-шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэх тайлагнах | | | | | | | | |
| 1.2.3.10 | Аймаг, нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэх тайлагнах | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний нэгдсэн тайлангийн тоо | 1 | 1 | 1 | Нийслэл, 21 аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан боловсруулсан. | 100 | 100 |
| 1.2.3.11 | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэх тайлагнах | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний нэгдсэн тайлангийн тоо | 1 | 1 | 1 | Яам, 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг нэгтгэн нэгдсэн тайлан боловсруулсан. | 100 | 100 |
| 1.2.3.12 | Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаар дүгнэж, тайлан боловсруулж, зөвлөмж хүргүүлэх | Улсын төсөв | Тайлангийн тоо | 38 | 38 | 38 | Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг нэгтгэн тайлан, танилцуулга, холбогдох шийдвэрийн төсөл зэргийг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанп танилцуулж, 25 дугаар тэмдэглэл гаргуулсан.<br>ЗГХХГ-ын 2025.09.08-ны өдрийн 01/942 дугаар албан бичгээр шинэчлэн баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын дагуу Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээгээр илэрсэн нийтлэг алдаа, дутагдалд үндэслэн уг журмыг нэг мөр хэрэгжүүлэхтэй холбоотой дараах асуудалд анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмжийг нийт 42 байгууллагад хүргүүлсэн. | 100 | 100 |
| | | | Зөвлөмжийн тоо | 38 | 38 | 38 | | | |
| 1.2.3.13 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн | Улсын төсөв | Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо | 336 | 336 | 336 | Яам, аймаг, нийслэлийн нийт 38 нэгжийн Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд (давхардсан тоогоор 336 шалгуур үзүүлэлтээр) хяналт шинжилгээ хийж, дүнг цахим системд | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийх | | | | | | оруулсан. Байгууллагын үйл ажиллагааны тайлан ЗГ-ын 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, тус өдрийн 25 дугаар тэмдэглэл гарсан. | | |
| 1.2.3.14 | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Улсын төсөв | Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо | 174 8 | 174 8 | 1748 | Яам, аймаг, нийслэлийн нийт 38 нэгжийн нээлттэй мэдээллийн ил тод байдлын давхардсан тоогоор 1748 үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, дүнг цахим системд оруулсан. Байгууллагын үйл ажиллагааны тайлан Засгийн газрын 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 25 дугаар тэмдэглэл гарсан. | 100 | 100 |
| 1.2.3.15 | УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний тайлангийн тоо | - | 1 | 1 | УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын 50 заалт, хавсралт төлөвлөгөөний 114 заалт тус бүрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, дүнг нэгтгэн, санал, зөвлөмж бичиж ЕТГ болон УИХ-ын Байгаль, орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсэгт тус тус танилцуулсан. Мөн тус тогтоолын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн 2025 оны 09 дүгээр сарын 10-11-ний хороонд "DEVAL"-тай хамтран зохион байгуулсан сургалтын үеэр танилцуулсан. | 100 | 100 |
| 1.2.3.16 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний тайлангийн тоо | - | 1 | 1 | Үндэсний Аудитын газраас мэдээлэл хүсэх тухай 2025 оны 01 дүгээр сарын 22-ны 03/346 тоот албан бичиг ирүүлсний дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, танилцуулга, холбогдох баримт материал, нотлох баримтын хамт хүргүүлэн ажилласан. | 100 | 100 |
| 1.2.3.17 | Үндэсний аудитын газраас бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд аудит гүйцэтгэлийн аудит хийхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | Улсын төсөв | Боловсруулж хүргүүлсэн албан бичиг, өгсөн тайлбар, мэдээлэл (тоо) | - | 2 | 2 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжилгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, тухайн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллүүдийг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/190, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/206, УИХ-ын Тамгын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/197 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн Үндэсний аудитын газраас Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 08/978 дугаартай албан бичгээр ирүүлсэн аудитын тайланг хүлээн авч, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газрын даргаар батлуулан Үндэсний аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/455 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах газруудад 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр дотоод албан бичгээр хүргүүлсэн бөгөөд явцын тайланг холбогдох газруудаас гаргуулан ажилласан. | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХУУЛЬ ЁСЫГ САХИУЛЖ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛНА** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилт 2.1 Засгийн газрын хяналт, шалгалтын үйл ажиллагааны үр нөлөө дээшилсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.1.1 Засгийн газрын хяналт шалгалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хийж, үр дүнг тайлагнах** | | Улсын төсөв | Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (Хувь) | - | 100 | 100 | **Нийт 9 арга хэмжээ төлөвлөж, тайлагнаснаас хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Тайлант хугацааны арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |
| 2.1.1.1 | Засгийн газар, Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын өгсөн үүрэг, шийдвэрийн дагуу Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | 100 | Засгийн газар, Ерөнхий сайд, Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын өгсөн үүрэг, шийдвэрийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороонд "Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг тогтоохтой холбоотой үйл ажиллагаа", "Эрдэнэс Монгол нэгдэл", "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ТӨХК-ийн, Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Гаалийн байгууллагын, Монгол Улсын Хөгжлийн банкны ил тод, нээлттэй байдлын, Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 4 байгууллагын, Монгол Улсыг олон улсад сурталчлах ажлын хүрээнд байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, үр дүнд, Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаа зэрэг 10 байгууллагад хяналт шалгалтыг хийж үр дүнг Ерөнхий хянан шалгагчид танилцуулсан. | 100 | 100 |
| 2.1.1.2 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | 100 | Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан тендерийн үйл ажиллагаа, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лабораторийн, Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн, тус аймгийн Эрүүл мэндийн газрын, МУИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн, Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ийн, Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан зарим тендерийн, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын, Хот байгуулалт, хотын стандартын газрын, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ зэрэг 14 байгууллагад хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа, ил тод байдалтай холбоотой бүх асуудлыг хэлтсийн хянан шалгагч нар шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох арга хэмжээг авсан. | | |
| 2.1.1.3 | Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ, тандалт судалгааг үндэслэн өөрийн санаачилгаар байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалтын тоо | - | 3 | 5 | Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ, тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээг үндэслэн байгууллагын 2025 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10.1.4-т 4 чиглэл гарган "Монголын төмөр зам ТӨХК", "Тавантолгой төмөр зам ТӨХК"-ийн, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Геологийн судалгаа шинжилгээний төв, Эрчис ойл ТӨХХК, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, үр дүнгийн чиглэлээр буюу нийт 8 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | 100 | 100 |
| 2.1.1.4 | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15.5-д заасан гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалтын тоо | 2 | - | 5 | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15.5-д заасны дагуу 2025 оны эхний хагас жилд Боловсролын яам, Боловсролын зээлийн сан, Орхон аймгийн ЗДТГ, Боловсролын ерөнхий газар, ХХҮЕГ зэрэг 5 байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | 100 | 100 |
| 2.1.1.5 | Хяналт шалгалтын дүнг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах санал, албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, биелэлтэд хяналт тавих | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 50 | 60 | 70 | 2025 онд 41 байгууллагад хийсэн хяналт шалгалтын хүрээнд 51 албан шаардлага, шаардлага хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, Баянхонгор аймгийн Засаг дарга, Дархан-Уул аймгийн Засаг дарга болон тэдгээрийн холбогдох албан тушаалтнуудтай холбоотой үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн. Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргаар уламжлуулан Баянхонгор, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт хариуцлага тооцуулах тухай саналыг Ерөнхий сайдад хүргүүлсэн.<br>Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу зөрчил, дутагдлыг тогтоосон хугацаанд арилгасан эсэхэд дүн шинжилгээ хийхэд биелэлт 84.7 хувьтай байна.<br>Хяналт шалгалтын дүнг үндэслэн 18 байгууллагын 25 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах саналыг албан шаардлага, албан бичгээр хүргүүлсэн бөгөөд 18 албан | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрээр сахилгын шийтгэл ногдуулсан байна. | | |
| 2.1.1.6 | Хяналт шалгалт хийсэн талаарх дүнг үндэслэн Ахлах хянан шалгагч, Ерөнхий хянан шалгагчийн мэдэгдэл, албан шаардлагыг хүргүүлж, биелэлтэд хяналт тавих | Улсын төсөв | Биелэлтийн хувь | 77 | 78 | 80 | Хяналт шалгалтын дүнг үндэслэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу яаманд 3, аймаг, нийслэлийн Засаг даргад 20, Засгийн газрын агентлагт 5, аймаг нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагт 8, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад 12, бусад байгууллагад 3, нийт 51 албан шаардлагыг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд яаманд 2, аймаг, нийслэлийн Засаг даргад 4, Засгийн газрын агентлагт 7, аймаг нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагт 1 нийт 14 мэдэгдэл хүргүүлсэн.<br>51 албан шаардлагын 35 буюу 88.3 хувь нь албан шаардлагын хариуг ирүүлсэн, биелэлт дунджаар 88.4 хувьтай байна. Хариу ирүүлээгүй 6 буюу 11.7 хувь нь хариу ирэх хугацаа болоогүй. Хүргүүлсэн 14 мэдэгдлийн хариу 100 хувь ирж биелэлт 97.5 хувьтай байна. | 100 | 100 |
| 2.1.1.7 | Хяналт, шалгалтын үр дүнд бодлогын судалгаа, шинжилгээ хийх | Улсын төсөв | Дүн шинжилгээний тайлан (тоо) | - | - | 1 | Тус газраас 2023 оноос хойш хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэл болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээлэл зэргийг үндэслэн судалгаа хийж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд бүтээмжийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашигт байдлыг дээшлүүлэх чиглэлээр яам, агентлагийн чиг үүрэг болон үндэсний зөвлөл, хороодын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл, тусгай зөвшөөрлийн тухай хууль, холбогдох систем, процессыг судлан, процессын дахин инженерчлэл хийх салбарыг тодорхойлон, санал боловсруулж, Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн дэд ажлын хэсэгт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр танилцуулсан. | 70 | 70 |
| 2.1.1.8 | Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээ болон хяналт шалгалт, | Улсын төсөв | Дүн шинжилгээний тайлан (тоо) | - | 1 | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрмийн 6.9.10-т "байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн хяналт шалгалтыг төлөвлөх"-өөр заасны дагуу тус газраас 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгах чиглэлийг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт-шинжилгээ, үнэлгээг үндэслэн Хяналт шалгалтын нэгжтэй 2025 оны хяналт шалгалтыг хамтран төлөвлөх | | | | | | боловсруулан, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Энэхүү чиглэл нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд бүтээмжийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашигт байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн асуудлуудыг хамарч байгаа бөгөөд дараах судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан болно. Үүнд:<br>-Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ;<br>-Хяналт шалгалтын газраас 2023, 2024 онд Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас өгсөн үүрэг болон өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээнд хийсэн хяналт шалгалт;<br>-Үнэлгээ, мониторингийн газраас 2023 онд яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ;<br>-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд 2023, 2024 онд хийсэн судалгааны үр дүн | | |
| 2.1.1.9 | Хянан шалгагчийн шийдвэр, хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэн хуулийн этгээдээс ёс зүйн асуудлаас бусад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээ авах | Улсын төсөв | Шийдвэрлэлтийн хувь | - | 100 | 100 | Иргэн Э.Төмөрбат, Г.Ганболд, Ю.Батхүү болон Боловсролын давлагаа ТББ-аас Хяналт шалгалтын газрын хянан шалгагчтай холбогдуулан гомдол гаргасан. Гомдлыг зохих журмын дагуу хянан үзэж хариуг өгсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилт 2.2. Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо нэмэгдсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2.1 Иргэд, олон нийтийн байгууллага, мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | **-** | **100** | **100** | **Нийт 9 арга хэмжээ төлөвлөж, тайлант хугацааны арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |
| 2.2.2.1 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж, хамтран ажиллах | Улсын төсөв | Хамтран хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажлыг зохион байгуулахад бэлтгэл ажлыг бүрэн хангаж 16 яам, 21 аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, судалгаанд бүрэн хамруулж төрийн байгууллагын оролцоог нэмэгдүүлсэн. | 100 | 100 |
| 2.2.2.2 | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд төрийн болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, шинжээч оролцуулах | Улсын төсөв | Хамтран гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоо | - | - | 2 | Тайлант хугацаанд Ерөнхий хянан шалгагчийн удирдамжаар батлагдсан Эрчим хүчний зохицуулах хороо, Эрдэнэс монгол ХХК-д хийгдсэн хяналт шалгалтад Үнэлгээ, мониторингийн газар, Тандалт, судалгаа, бодлого төлөвлөлтийн газруудаас 4 шинжээчдийг "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд оруулж хамтран ажиллаж үр дүнг тооцсон. | 100 | 100 |
| 2.2.2.3 | Монголын Үнэлгээний холбоотой санамж бичиг байгуулах | Улсын төсөв | Байгуулсан санамж бичгийн тоо | - | 1 | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Монголын Үнэлгээний холбоо нь 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллагатай хамтран Германы хөгжлийн үнэлгээний институт (DEval)-ийн тусламжтайгаар "Улсын үнэлгээний чадавхын индекс" (INCE)-ийг тогтоох, Дэлхийн банкны Олон улсын үнэлгээний санаачилга (GEI)-ын дэмжлэгтэйгээр Мониторинг, үнэлгээний тогтолцооны шинжилгээ (MESA)-г хэрэгжүүлэх, Мониторинг, үнэлгээний чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хөгжлийн бодлогын үнэлгээ хийхэд цаашид хамтран ажиллахаар болсныг албан ёсоор баталгаажуулж хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2.4 | Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Судалгааны тайлан | - | 1 | 1 | **1.**"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай эсэхэд 2024 оны хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, дүгнэх удирдамж"-ийн төсөл боловсруулж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар батлуулсан.<br>**2.**ЗГХХГ-ын даргын "Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа зохион байгуулах тухай" 2025.04.07-ны өдрийн 01/424, 01/425 дугаар албан бичиг, түүний хавсралт удирдамж, судалгааны санал асуулгын хуудсыг албан бичгийн хавсралтаар яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын нийт 38 нэгжид хүргүүлэн судалгаа авч, дүнг нэгтгэн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээнд тайланд тусгасан. Судалгааны дүн нэгтгэгдэн 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хуралдааны 25 дугаар тэмдэглэл гарсан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2.2 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | 100 | **Энэ зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |
| 2.2.2.1 | Бусад байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн хариутай өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих. | Улсын төсөв | Хэрэгжилтийн дундаж хувь | 44,5 | 50 | 60 | Энэ онд 332 өргөдөл, гомдол, 471 албан бичгийн хүлээн авч үүнээс төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, 56 өргөдөл, гомдол албан бичгийг шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн бөгөөд 24 өргөдөл, гомдлын хариуг манай газарт ирүүлсэн байна. | 100 | 71 |
| 2.2.2.2 | Төрийн байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Улсын төсөв | Сургалт (тоо) | 3 | 1 | 1 | 1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ боловсруулахад анхаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгч, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын өргөдөл, гомдол хариуцсан 500 гаруй мэргэжилтнүүдийг хамруулан 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр цахим сургалт зохион байгуулсан.<br>Сургалтаар иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ нэгтгэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудал болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаа, өргөдөл, гомдлыг хүлээн авах системийн танилцуулга, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайлан мэдээ нэгтгэх, тайланд дүн шинжилгээ хийх арга зүй, туршлагын талаарх мэдээллийг өгч, арга зүйн удирдлагаар хангасан.<br>2."Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам" батлагдсантай холбогдуулан журмын зохицуулах харилцаа, өргөдөл, гомдлын талаарх тайлан, мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх, хүргүүлэхтэй холбоотой зохицуулалтыг танилцуулах цахим сургалтыг яам, агентлаг, орон нутгийн ЗДТГ-ын өргөдөл, гомдол, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад зохион байгуулав. | | |
| 2.2.2.3 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах | Улсын төсөв | Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн чанарын дундаж үзүүлэлт | 86 | 88 | 90 | Тайлант хугацаанд иргэдээс гомдол 267, санал 5, хүсэлт 50, талархал 1, шаардлага, шүүмжлэл 9 нийт **332** өргөдөл, гомдол хүлээн авч 310 буюу 96.8 хувийг шийдвэрлэсэн, 22 өргөдөл гомдол буюу 3.2 хувь нь хяналтад байна.<br>Засгийн газар, яамд, Засгийн газрын агентлаг, аймаг нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээд, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдээс нийт 471 албан бичгийг хүлээн авсан. Үүнээс хариутай 119, хариугүй 352 албан бичиг байна. 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 97.4 хувийг шийдвэрлэж 2.6 хувь нь шийдвэрлэх шатанд байна. | 100 | 100 |
| 2.2.2.4 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын дүн мэдээ, шийдвэрлэлтийн байдалд шинжилгээ хийж, үнэлгээ, дүгнэлт гаргах | Улсын төсөв | Үнэлгээний тайлан (тоо) | 1 | 1 | | Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын 2024 оны жилийн эцэс болон 2025 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн, тоо, хэмжээ, төрөл, хүлээн авсан хэлбэр, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт, шинжилгээ хийж ажилласан. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоог өмнөх онтой харьцуулахад 27.9 хувиар, шийдвэрлэлт 4.2 хувиар тус тус буурсан нь байгууллагын дотоод үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хүсэлт, техникийн дуудлага, лавлагаа зэргийг тайлан мэдээнд оруулахгүйгээр ангилал, бүртгэлийг зөв хийж эхэлсэнтэй холбоотой байна. Өргөдөл гомдлын дүн мэдээг нэгтгэн, дүгнэлт, саналын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100 | 100 |
| 2.2.2.5 | "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг | Улсын төсөв | Тайлан (тоо) | 2 | 2 | 2 | Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах "11-11" төвд хандаж гаргасан | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгаж хүлээн авах, нэгтгэн, үр дүнг Засгийн газарт тайлагнах | | | | | | өргөдөл, гомдлын 2024 оны жилийн эцэс болон 2025 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн, шийдвэрлэлтийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн дүгнэлт, саналын хамт хуралд хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын хуралдаанд 2 удаа танилцуулан, 2025 оны 04 сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдааны 15, 2025 оны 09 сарын 10 өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл гаргуулан, холбогдох төрийн байгууллагуудыг үүрэгжүүлэн ажилласан. | | |
| 2.2.2.6 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх | Улсын төсөв | Үнэлгээний тайлан (тоо) | - | 1 | 1 | Тус арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1.Эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, байгаль орчин, хууль зүй, хот байгуулалтын салбар болон Дорнод, Дархан-Уул аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд санамсаргүй түүврийн аргаар сонголт хийж, нийт 1066 иргэнийг хамруулсан. 54.2 хувь нь гомдол, өргөдөл нь шийдвэрлэгдсэн гэсэн боловч эдгээрийн 63.6 хувь нь шийдвэрлэлтийн чанар хангалтгүй, дутуу буюу бүрэн гүйцэд шийдвэрлэгдээгүй, сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 94 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор, гадаадын хөрөнгө оруулалтын 73 хувийг бүрдүүлдэг уул уурхай, олборлох салбар, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд иргэдээс ирүүлсэн гомдолд тандалт судалгаа хийхэд иргэдийн 54.1 хувь нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн. Энэхүү тандалт судалгааны дүн нь төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны чанарыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.<br>3.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны 04 сарын 07-ны өдрийн А/62 тушаалаар төрийн байгууллага, албан тушаалтны 2024 оны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай байсан эсэхэд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, тайлагналтын байдал, иргэдийн сэтгэл ханамжийг тандан судалсан байдалд удирдамжийн дагуу үнэлгээ өгч, үнэлгээний үр дүнг нэгтгэн, ҮМГ-т хүргүүлсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЗӨВЛӨН ЧИГЛҮҮЛНЭ** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилт 3.1 Процессын дахин инженерчлэл, сайн туршлагын үр дүнд төрийн үйлчилгээний чанар, бүтээмж сайжирсан байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 3.1.1 Төрийн байгууллагуудад процессын дахин инженерчлэл хэрэгжүүлэх, зөвлөн чиглүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, бүтээмжийг сайжруулах** | | Улсын төсөв | Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь) | - | 100 | 100 | **Энэ зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ төлөвлөсөн.** | | |
| 3.1.1.1 | Төрийн байгууллагад процессын дахин инженерчлэлийг хийх заавар, гарын авлага боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах | Улсын төсөв | Батлагдсан баримт бичиг (тоо) | - | 1 | 1 | Засгийн газрын 2024 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл (GPR) хийх нийтлэг аргачлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүргийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт үүрэг болгоны дагуу тус гарын авлагын төслийг боловсруулсан.<br>Процессын дахин инженерчлэлийн (GPR) нийтлэг аргачлал/зааврын төслийг олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулж УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Удирдлагын академи, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, ОУ-ын байгууллагууд зэрэг нийт 41 байгууллагын 100 гаруй төлөөлөл хамрагдаж 90 гаруй санал өгснийг тусгасан.<br>МУЗГ-ын 2025 оны 78 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан аргачлалын төсөлд нэмэлт сайжруулалтыг хийж, төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрт оруулахаар Удирдлагын академитай хамтран ажиллаж байна. | 100 | 70 |
| | | | Хуралдааны тэмдэглэл (тоо) | - | - | 1 | УИХ-ын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан процессын дахин инженерчлэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулах хүрээнд "Процессын дахин инженерчлэлийн (GPR) заавар"-ын төслийг УИХ-ын Төрийн байгуулалтын болон Инновац, цахим бодлогын байнгын хороодын хамтарсан хуралдаанд | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 05 дугаар 28-ны өдөр танилцуулсан. Тус төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна. | | |
| 3.1.1.2 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийх | Улсын төсөв | Тайлан (тоо) | - | 1 | 1 | Процессын дахин инженерчлэлийн (GPR) судалгаа, шинжилгээний ажлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газарт хийж гүйцэтгэлээ.<br>Бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах, салбарын эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, төрийн үйлчилгээний чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор процессыг бууруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэх, хүний нөөцийн стратеги болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд 68 дүгнэлт, 54 санал, зөвлөмжийг өгсөн.<br>Судалгааны дэлгэрэнгүй болон хураангуй тайланг боловсруулан холбогдох талуудад хүргүүлж, санал, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын даргын 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/685 дугаартай албан бичгээр БОУАӨЯ-д хүргүүлж, ажлын үр дүнг 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр холбогдох албан хаагчдад танилцуулж, хүлээлгэж өгсөн. | 100 | 100 |
| 3.1.1.3 | Процессын дахин инженерчлэлийн ажлын үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах | Улсын төсөв | Хуралдааны тэмдэглэл (тоо) | - | 1 | 1 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газарт хийсэн процессын дахин инженерчлэлийн (GPR) судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд боловсруулсан тайлан, зөвлөмж, үр дүнг Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр албажуулсан. | 100 | 100 |
| 3.1.1.4 | Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийж, нөхцөл байдлын шинжилгээний үндсэн дээр дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах | Улсын төсөв | Тайлан, зөвлөмж (тоо) | - | - | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/69 дугаар тушаал, мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын болон Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/71, А/175 дугаар хамтарсан тушаалын баталсан.<br>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээг 2024 оны 11 дүгээр сараас эхлүүлэн холбогдох уулзалтыг зохион байгуулан баримт бичгийн шинжилгээг гүйцэтгэж, 2025 оны 4 дүгээр сард Хамтарсан ажлын хэсгийг байгуулж 85 албан хаагчтайгаар тус салбарын бүтцийг оновчтой болгох, чиг | 100 | 100 |
| 3.1.1.5 | Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн процессын | Улсын төсөв | Хуралдааны тэмдэглэл (тоо) | - | - | 1 | үүргийн давхардал, хийдлийг арилгах, хүнд суртлыг багасгах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах судалгаа, шинжилгээг олон улсад өргөнөөр | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дахин инженерчлэлийн ажлын үр дүнг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний хорооны даргад танилцуулах | | | | | | ашиглагддаг 8 арга зүй, аргачлалын дагуу сонгогдсон 11 нэгжид хийж гүйцэтгэж оновчтой шийдэл бүхий 75 дүгнэлт, 74 санал, зөвлөмж бүхий судалгааны тайланг боловсруулж Байгууллагын даргын 2025/10/28-ны өдрийн 01/1061 дугаар албан бичгээр ХЗДХЯ, ЦЕГ-т хүргүүлж, үр дүнг танилцуулах уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.<br>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад процессын дахин инженерчлэлийн (GPR) судалгаа, шинжилгээ хийж үр дүнгийн тайланг ЗГ-т 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд танилцуулж ЗГ-ын 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр албажсан.<br>(Монгол Улсын Засгийн газрын 2025.07.09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Хяналт, үнэлгээний хороо татан буугдсан болно.) | | |
| 3.1.1.6 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа агентлагаас олгож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нөхцөл байдлын шинжилгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлэх | Улсын төсөв | ПДИ-ийн ажилд ажилласан багуудын тайланг боловсруулж үндсэн багт хүргүүлсэн хувь | - | 100 | 100 | БОУАӨЯ, Ойн газарт ПДИ хийх ажлын хүрээнд ажлын хэсгийн эрсдэлийн удирдлага, хуулийн багт ХЭЗГ-ын албан хаагчид орж ажиллан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Эрсдэлийг тодорхойлох хүрээнд СЭЗИС-аас зохион байгуулсан эрсдэлийн үнэлгээний сургалтад хамрагдан үнэлгээ хийх арга зүйг шинэчлэн боловсруулсан. Шинэчлэн боловсруулсан арга зүйн дагуу шаардлагатай дата мэдээллийг цуглуулж, иргэн, ААН, ТАХ-тай ярилцлага хийн асуудлын бүртгэл хөтлөн, асуудлаас эрсдэлийг тодорхойлж үнэлэн эрсдэлийн матрицыг гарган тайлан боловсруулж стратегийн багт хүлээлгэн өгсөн.<br>2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг судалж, хэм хэмжээний акт болон энгийн, тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан.<br>3. БОУАӨЯ, Ойн газарт салбарын хууль тогтоомжоор оноосон чиг үүрэг, батлагдсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 3.1.2 Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцоо бүхий загвар байгууллагын** | | **Улсын төсөв** | **Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | **100** | **Энэ зорилтын хүрээнд 1 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилт 100%** | **100** | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх** | | | | | | | | | |
| 3.1.2.1 | "Төрийн байгууллагуудын төгөлдөршлийн тогтолцооны загвар төсөл"-ийг Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), Улсын Хоёрдугаар төв эмнэлэгт хэрэгжүүлэх | ОУБ-ын төсөв | Хэрэгжилтийн эзлэх хувь | - | - | 100 | Монголын бүтээмжийн төвтэй байгуулах гэрээний төсөл болон хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг 5 үе шаттайгаар 11 сарыг хүртэл хэрэгжүүлэхээр боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 3 талт гэрээг байгуулан дараах байгууллагуудад хэрэгжүүлж "Азийн загвар байгууллага"-ын гэрчилгээг Азийн бүтээмжийн байгууллагаас гардан авсан. Үүнд:<br>1. **Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар** "Өгөгдөлд суурилсан үйл ажиллагаагаар иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх";<br>2. **Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг** "Өвчний түүх нээх үйл ажиллагааг сайжруулах";<br>3. **Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар** "Ажилчдын болон даатгуулагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх";<br>4. **Нийслэлийн Засаг даргын Тамгын газар** "ААНБ-удын орчны 50 метрийн цэвэрлэгээг сайжруулах" төслүүдийг гэрээ болон төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг явцад зөвлөн тусалж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.<br>Төсөл хэрэгжүүлсэн 4 байгууллага Монгол Улсад анх удаа төрийн байгууллагуудад төгөлдөршлийн тогтолцоог нэвтрүүлж, олон улсын түвшинд үнэлэгдсэн. Энэхүү загвар байгууллагын статус нь төрийн захиргаа, үйлчилгээний чанар, үр нөлөө, ил тод байдлыг системийн түвшинд сайжруулж байгааг нотлохын зэрэгцээ Монголын байгууллагууд олон улсын сайн туршлага түгээх чадвартай болсныг харуулж байна.<br>Төслийн зөвлөхөөс ирүүлсэн болон Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээг бие даан гүйцэтгэх агуулга бүхий гарын авлагыг Англи эх хувилбартай нь харьцуулан орчуулга, утга, агуулгыг хянан засварлаж, дутуу мэдээлэл агуулгыг нөхөх замаар нийт 60 хуудас гарын авлага боловсруулсан.<br>Төрийн байгууллагын бүтээмжийн стратегийг боловсруулах, замын зураг боловсруулах арга зүйн нэгдсэн сургалтыг танхимаар 4 удаа, цахимаар 7 удаа хийж, нийт давхардсан тоогоор 400 гаруй албан хаагчдыг хамруулсан. Тус 3 талт гэрээний хэрэгжилтийг дүгнэх, төслийн хаалтын хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Гүйцэтгэлийн зорилт 3.1.3 Тасралтгүй сайжруулалт, процессын дахин инженерчлэл хийгдсэн байгууллагын хяналтыг тогтмолжуулах** | | **Улсын төсөв** | **Арга хэмжээний хэрэгжилтийн хувь** | - | - | **100** | **Энэ зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилт 100%** | | |
| 3.1.3.1 | Процессын дахин инженерчлэл хийгдсэн байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах | Улсын төсөв | Зөвлөмжийн хэрэгжилт (хувь) | - | 20 | | 1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл судалгаа шинжилгээг хийж, тайлан зөвлөмжийг байгууллагын даргын 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/685 дугаартай албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн зөвлөмжийг 2026 онд багтаан хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.<br>2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллага дахь ПДИ-ийн судалгаа, шинжилгээ хийж, тайлангаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд 2026 оны 1 дүгээр улиралд үнэлгээ, дүн шинжилгээ хийж, дүгнэж тайлан гаргана.<br>3. ЗГХХГ- аас 2023 оноос хойш ГБХНХЯ (2023 он), ЭМЯ (2024 он), БОУАӨЯ (2025 он), ЦЕГ (2025 он), ГЕГ (2025 он) зэрэг нийт 4 байгууллага түүний зарим харьяа (20) нэгжийн үйл ажиллагаанд ПДИ-г судалгаа шинжилгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлсэн байна. Хугацааны хувьд процессын хяналт хийх, зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх нөхцөл байдал 2 байгууллагад үүссэн бөгөөд тус 2 байгууллагад хүргүүлсэн ПДИ-ийн зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан ирүүлэх тухай албан тоотыг хүргүүлж, ирүүлсэн тайланд дүгнэлт зөвлөмж боловсруулж ажилласан.<br>4.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 01/1950 дугаар албан бичгээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Засгийн газрын 2022-2025 оны зарим тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүн, "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын зохицуулалтад шинжилгээ, процессын зураглал хийх, Гаалийн төв лабораторийн нүүрсний дээжийн магадлан шинжилгээ, дүгнэлт гаргах явцад Ерөнхий хянан шалгагчийн 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01/19 дүгээр удирдамжийн хүрээнд хяналтыг хийж гүйцэтгэж 2025 оны 08 дугаар сарын 19-ны өдөр тандалт судалгаа, эрсдэлийн дүн шинжилгээний тайлан хүргүүлсний дагуу Гаалийн ерөнхий газар тус хугацаанд зөвлөмжөөр үйл | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг цахимжуулах асуудлын 40 хувь цахимжсан байна. | | |
| 3.1.3.2 | Процессын дахин инженерчлэлийг хийх аргачлал, гарын авлагыг ашиглах, хэрэгжүүлэх чиглэлээр хүний нөөц бэлтгэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Улсын төсөв | Хэлэлцүүлэг, сургалт (тоо) | - | 1 | | Засгийн газрын 2024 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл (GPR) хийх нийтлэг аргачлалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүргийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт даалгасан.<br>Энэ хүрээнд "Процессын дахин инженерчлэлийн (GPR) заавар", гарын авлагын төслийг боловсруулаад байна.<br>Төслийг 2 удаа хэлэлцүүлж, гарсан саналуудыг тусган төрийн байгууллагуудын онцлог, бүтэц, чиг үүрэгт нийцүүлэн энэхүү аргачлалыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.<br>УИХ-ын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар байгуулагдсан процессын дахин инженерчлэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, санал, дүгнэлт гаргах бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт мэдээллийг танилцуулах ажлын хүрээнд тус төслийг УИХ-ын Төрийн байгуулалтын болон Инновац, цахим бодлогын байнгын хороодын /2025.05.28/ хамтарсан хуралдаанд танилцуулсан. | 80 | 80 |
| **Стратегийн зорилт 3.2. Эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 3.2.1 Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх** | | Улсын төсөв | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | 100 | **Энэ зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Гүйцэтгэсэн 2 арга хэмжээний хувьд биелэлтийн дундаж нь 100 хувь байна.** | **100** | |
| 3.2.1.1 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гарын авлага гаргах | Улсын төсөв | Гарын авлага (тоо) | - | - | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны А/191 дүгээр тушаалаар "Эрсдэлийн удирдлагын нийтлэг журам, гарын авлага боловсруулах" ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын баримт бичгийг хэрэгжүүлэх, ашиглах аргачлал заавар бүхий гарын авлагыг эцэслэн боловсруулж, цахим хэлбэрээр портал сайтад байршуулан, нийтэд түгээхээр ажиллаж байна. | 70 (ХБ) | 70 |
| 3.2.1.2 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх | Улсын төсөв | Бэлтгэгдсэн багш (тоо) | - | 10 | 10 | Төрийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд 10 модуль сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулан, хичээлийн агуулгад албан хаагчдаас санал авч, сургалтын материалыг бэлэн болгосон.<br>Байгууллагын албан хаагчдын эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ойлголт дээшлүүлэх зорилгоор Эрсдэлийн | 100 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдлагын хэлтсийн албан хаагчид болон байгууллагын газар, хэлтсийн төлөөллүүдээс бүрдсэн 25 албан хаагчийг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр сургалтад хамруулсан. Мөн сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр эрсдэлийн удирдлагын хэлтсийн албан хаагчдын сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | | |
| 3.2.1.3 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулах | Улсын төсөв | Оролцогчдын (тоо) | - | 150-иас доошгүй | | "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нь" хэлэлцүүлгийг 2025 оны 2 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, яам, агентлагууд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, олон улсын болон судалгаа шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн 85 байгууллагын 150 гаруй төлөөлөл оролцуулан зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр төрийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцооны өнөөгийн байдал судалгааны үр дүнг танилцуулж, Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого, заавран төслийн баримт бичгийг хэлэлцүүлэн санал, зөвлөмж авч, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа сайн туршлагуудаас хуваалцан, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд тулгамдаж буй асуудал, тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцлээ.<br>Эрсдэлийн удирдлагыг төрийн байгууллагуудад үр дүнтэй хэрэгжүүлэх, сайн туршлагыг хуваалцах арга хэмжээ зохион байгуулах, эрсдэлийн удирдлагын сургалт хийх, хүний нөөцөө бэлдэх, нэгдсэн бодлогын баримт бичигтэй болох асуудлууд нэн чухал шаардлагатай зэрэг санал гарсан болно. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 3.2.2 Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | **-** | **-** | **100** | **Энэ зорилтын хүрээнд 1 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |
| 3.2.2.1 | 21 аймаг, 9 дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдын төлөөллийг хамруулсан | Улсын төсөв | Оролцогчдын ( тоо) | - | 50-иас доошгүй | | "Хамтын хөгжил – Сайн туршлага" зөвлөгөөнийг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн ЗДТГ-ын болон Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, мэргэжилтэн, Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн төлөөлөл зэрэг 150 гаруй албан хаагчдыг оролцуулан, эрсдэлийн удирдлагын талаарх олон улсын чиг хандлага, онол арга зүй, практик хэрэглээ, инновацын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүлсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | туршлага судлах, мэдээлэл солилцох хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах | | | | | | Оролцогчдод "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг"-ийг танилцуулж, төрийн өмчит үйлдвэрийн газруудын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн сайн туршлагыг хуваалцах, мэдээлэл солилцох, харилцан суралцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Мөн Их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид, судалгааны байгууллагын төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллага, оюутнуудын дунд эрдэм шинжилгээний хурал, эссе бичлэгийн уралдаан зохион байгууллаа. | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 3.2.3 Төрийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | 100 | 100 | **Энэ зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн.** | **100** | |
| 3.2.3.1 | Төрийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдүүлэх | Улсын төсөв | Баримт бичиг, аргачлал, зааврын тоо | - | 3 | 3 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны А/191 дүгээр тушаалаар "Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, гарын авлага боловсруулах ажлын хэсэг" байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого"-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлэг, санал авах ажлыг үе шаттай гүйцэтгэсэн. Үүнд:<br>-16 яам, 38 агентлагийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан;<br>-Байгууллагын дотоод 6 газар, нэгжээс санал авч, тусган боловсруулсан.<br>Бодлогын баримт бичгийг Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 | 100 |
| 3.2.3.2 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар, хэрэгжилтийг үнэлэх аргачлалын төсөл боловсруулах | Улсын төсөв | Заавар (тоо) | - | 1 | 1 | "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар" -ын төслийг боловсруулан, 16 яам, 38 агентлагийн төлөөллийг оролцуулан, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн, тусгаж, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаартай тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлуулсан.<br>Энэхүү заавар нь "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд эрсдэлийн засаглал ба соёл, хүрээ, үйл явц, эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбоо, хяналтын тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх ач холбогдолтой. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Улсын төсөв | Үнэлэх аргачлал (тоо) | - | 1 | | Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлалын төслийг боловсруулан холбогдох яамдаас санал авч, төсөлд тусган Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлууллаа. Тус аргачлал нь Яам, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны түвшинг тодорхойлох, цаашид сайжруулах, тасралтгүй хөгжүүлэх механизмыг бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд байгууллага нь эрсдэлийн удирдлагын төлөвшлийг үнэлэх, сайжруулах арга зүйг тусган боловсруулсан. | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛНЭ** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилт 4.1. Цахим технологийн оновчтой шийдэлд тулгуурласан мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт** 4.1.1 Судалгаа, шинжилгээ, үнэлгээ, мониторинг, хяналт шалгалтын үйл ажиллагааг автоматжуулах, их өгөгдөл, хиймэл оюун ухааны технологийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд МТСШГ-аас зөвлөмж, дэмжлэг үзүүлж ажиллах | | Улсын төсөв | Дэмжлэг үзүүлж ажилласан байдал Тийм-1, Үгүй-0 | 1 | 1 | 1 | | | |
| 4.1.1.1 | Холбогдох нэгж, ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан санал зөвлөмж, хүргүүлж ажилласан байх | Улсын төсөв | Санал, зөвлөмж хүргүүлж ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | Мэдээллийн технологи, системийн шинжилгээний газар нь:<br>-Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Ухаалаг засаг-2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд үнэлгээний цахим систем хөгжүүлэхэд зориулж 750,0 мянган ам.доллар тусгуулав. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн системийн ажлын даалгаврын эхний хувилбарыг боловсруулж, ЗГ-ын ХЭГ-т 2025.10.30-ны өдөр цахимаар хүргүүлэв. Үнэлгээний цогц системийн ажлын даалгаврыг ХЭГ-аас өгсөн зөвлөмжийг үндэслэн "Мэдээллийн системийн шаардлага"-7 дугаар зааварчилгааны дагуу шинээр боловсруулж, 2025.11.27-ны өдөр ЗГ-ын ХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн референтийн мэйл хаягаар хүргүүлсэн.<br>-DME хүрээнд Үнэлгээ мониторингийн газраас зохион байгуулсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чуулганы үйл ажиллагаанд ажлын хэсэгт орон тайзны дэлгэц, болон танхимын микрофон, дуугаралтын систем, презентацийг бүрдүүлж дэлгэц дээр гарган техникийн бүхий л ажиллагаа дээр хяналт тавин ажиллав. Мөн уг арга хэмжээний оролцогчдын сертификат болон мандатын эхийг бэлтгэж хэвлэлтийн ажлыг хариуцсан.<br>-Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /unelgee.gov.mn/-г шинэчлэн боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт хүргүүлсэн.<br>- Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн төрийн байгууллагад ашиглаж буй дотоод удирдлагын системээс өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санд төрийн мэдээлэл солилцооны "Хур" системээр дамжуулан тухай бүр нэгтгэх ажлыг эхлүүлсэн. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын бүртгэлийг ангилж, шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, бодит шалтгаан нөхцөлийг тогтоох, Иргэд, олон нийттэй харилцах /1111/ төв болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд ашиглаж буй мэдээллийн сан, дуудлагын утсыг нэгтгэх асуудлыг судалж, үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн /ЗГХЭГ, ЗГХХГ, ЦХИХХЯ/ хамтран дараах арга хэмжээг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23.1.2 дахь заалтыг үндэслэн 1111 төвийн мэдээллийн системийг "Мэдэгдэл хүргэх систем"-тэй холбож, улмаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн явц, шийдвэрийн талаар иргэдэд мэдэгдэл хүргэдэг болгосон.<br>-Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-ээр дамжуулан 11-11 төвд ирсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон нийслэлийн хэмжээнд дуудлагын утасны мэдээллийг дашбоард хэлбэрээр харах боломж бүрдсэн. 3. Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан "IVA" системийг "11-11.mn" вэб хуудастай холбож, "Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ"-г туршиж, Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулсан. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -ЗГХХГ-ын "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам"-ыг Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн боловсруулсан. Эрсдэлийн удирдлагын журам батлагдсанаар мэдээллийн системийн цар хүрээ, оролцогч талуудыг үүрэг тодорхой болох тул хүлээгдэж байна. | | |
| 4.1.1.2 | Хэрэгцээт тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаар хангасан байх | Улсын төсөв | Хэвийн үйл ажиллагаар хангаж ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | Шаардлагатай тоног төхөөрөмж болон системийг суурилуулах сервер, цахим орчныг бэлэн болгож inspection.gov.mn системийг ажиллуулав. | 90 | 90 |
| 4.1.1.3 | Төрийн бүртгэл, мэдээллийн байгууллагуудын цахим системийн мэдээллийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах ажлыг эхлүүлэх | Улсын төсөв | Цахим мэдээллийн системийн тоо | - | 1 | 1 | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглахаар Төрийн худалдан авах ажиллагааны газраас "Худалдан авах ажиллагааны цахим системд нэвтрэх эрх"-ийг 1 алба хаагчид олгуулж хяналт шалгалтад ашиглаж байна. | 100 | 100 |
| 4.1.1.4 | Хяналт шалгалтын цахим мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэх | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 50 | 100 | Хяналт шалгалтын мэдээллийн сан (цаасан болон цахим) http://inspection.ags.gov.mn/-г үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хянан шалгагч нар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 395 өргөдөл, гомдол, 25 хяналт шалгалт, түүний явцын тэмдэглэл, шийдвэрлэсэн байдал зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.1.2 Хяналт шалгалтын цахим мэдээллийн санг нэвтрүүлж, хөгжүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | **100** | **100** | **Энэ зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилтийн дундаж хувь 100% байна** | **100** | |
| 4.1.2.1 | Холбогдох нэгж, ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан санал зөвлөмж, хүргүүлсэн байна | Улсын төсөв | Тоо | - | 1 | 1 | Хяналт шалгалтын газрын өргөдөл, гомдлын системийн хөгжүүлэлтийн явцад холбогдох нэгж, ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан тухай бүрд санал зөвлөмж, хүргүүлж ажиллав. | 100 | 90 |
| 4.1.2.2 | Хэрэгцээт тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаар хангасан байна | Улсын төсөв | Тийм/1/ Үгүй/0/ | - | - | 1 | Шаардлагатай тоног төхөөрөмж болон системийг суурилуулах сервер, цахим орчныг бэлэн болгож туршилтаар системийг суурилуулж ажиллуулав. "Өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардлыг тогтоон, дүн | 100 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тодруулах, хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлсэн нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардлагатай шийдлийг боловсруулж, ажлын хэсгийн тайлангаар танилцуулсан. | | |
| 4.1.2.3 | Хяналт шалгалтын цахим мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэх | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | | 50 | 100 | Хяналт шалгалтын мэдээллийн сан (цаасан болон цахим) www. http://inspection.ags.gov.mn/-г үйл ажиллагаандаа ашиглахаар хянан шалгагч нар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хүлээн авсан 340 өргөдөл, гомдол, 15 хяналт шалгалтын мэдээллийг оруулсан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.1.3** Бодлогын хэрэгжилт, судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулах, хэлэлцүүлэх цахим дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд **Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан хөгжүүлэх** | | **Улсын төсөв** | **Үнэлгээ, мониторингийн системийн хөгжүүлэлт** | - | **5** | | **Бодлогын хэрэгжилт, судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулах, хэлэлцүүлэх цахим дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан хөгжүүлэхэд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтыг мэдээллийн системд бүртгэж, хяналтад авч мэдээллийн сан бүрдүүлж ажилласан.** | **93,3** | |
| | | | **Заалтын тоо** | - | - | 750-с доошгүй | | | |
| | | | **Санд оруулах шалгуур үзүүлэлтийн тоо** | - | - | 500-аас доошгүй | | | |
| 4.1.3.1 | Хяналт шалгалтын дүн, тайлан, судалгаа болон өөрийн үйл ажиллагаанд хамаарах хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээллийг холбогдох газарт хүргүүлэх | Улсын төсөв | Мэдээлэл хүргүүлсэн тоо | **5** | **3** | **6** | Хяналт шалгалтын газраас 2025 онд албан 41 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, хяналт шалгалтын үр дүнг Ерөнхий хянан шалгагчид танилцуулан, ЗГХХГ-ын дарга бөгөөд ерөнхий хянан шалгагч хэвлэл мэдээлэлд болон байгууллагын албан ёсны цахим хуудсаар болон бусад мэдээллийн хэрэгслээр хяналт шалгалтын мэдээллийг 18 удаа нийтэд мэдээлсэн. | 100 | 100 |
| 4.1.3.2 | Хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн сан бүрдүүлэх | Улсын төсөв | Санд оруулах шалгуур үзүүлэлтийн тоо | - | | 500-аас доошгүй | Аймаг, нийслэлээс ирүүлсэн 1051 шалгуур үзүүлэлт, мөн яам, олон улсын KPI чанарын үзүүлэлтийн судалгааг 11 салбараар нэгтгэсэн бөгөөд дээрх шалгууруудыг утга болон бодлогоор ангилан нэгтгэх ажил хийгдэж байна. | 80 | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3.3 | Шинээр баталсан журмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой системийн хөгжүүлэлт хийх | Улсын төсөв | Системд шинээр нэвтрүүлсэн маягтын тоо | - | - | 5 | "Үндэсний дата төв" УТҮГ-т "Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлт хийх, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/266 дугаар албан бичиг хүргүүлсэн бөгөөд тусгайлан сервер байрлуулахгүйгээр үүлэн байдлаар өгөгдлийг хадгалах (Mcloud үйлчилгээ) боломжтой талаар хариу ирүүлсэн. Мөн Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд 2024-2028 онд ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тайлангийн загвар болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дэд систем дээр сайжруулалт хийх саналыг системийн удирдагчид өгч, шинээр хөгжүүлэлт хийлгэсэн. | 100 | 100 |
| 4.1.3.4 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтыг мэдээллийн системд бүртгэж, хяналтад авах, хяналтаас хасах | Улсын төсөв | Бүртгэсэн заалтын тоо | 250 | 250-аас доошгүй | 250-аас доошгүй | Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтыг тухай бүр https://new.unelgee.gov.mn/law/ системд бүртгэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт Засгийн газрын тогтоол **76** шийдвэрийн **165**, Ерөнхий сайдын **2** албан даалгаврын **184** заалтыг тус тус хяналт шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим санд заалт бүрээр бүртгэн, хяналтад авч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.<br>Хяналт шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим санд бүртгэлтэй байгаа шийдвэрүүдээс хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн 1357 заалтыг бүрэн хэрэгжсэн, чиг үүрэгт хамааралгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг үндэслэлүүдээр хяналтаас хассан. | 100 | 100 |
| | | | Хасагдсан заалтын тоо | - | 500-гаас доошгүй | 500-гаас доошгүй | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.1.4 Эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан бий болгох, хөгжүүлэх** | | Улсын төсөв | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | **100** | **Энэ зорилтын хүрээнд нийт 3 арга хэмжээ төлөвлөсөн байна.** | **100** | |
| 4.1.4.1 | Эрсдэлийн удирдлагын мэдээллийн санг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулах | Улсын төсөв | Батлагдсан шийдвэр (тоо) | - | - | 1 | Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Голомт банкны Эрсдэлийн удирдлагын газартай уулзалт зохион байгуулж, төрийн байгууллагад эрсдэлийн мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх тухай санал солилцсон. Мөн эрсдэлийн удирдлагын мэдээллийн сангийн бүтцийн зураглалыг боловсруулах, мэдээллийн системийн шинжээчийг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулсан. Төрийн байгууллагын хэмнэлтийн зарчимд тулгуурлан мэдээллийн санг Power BI болон бусад программ ашиглан бий болгох зорилго тавин холбогдох албан хаагчдад сургалт зохион | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулаад байна. Мэдээллийн сангийн дашбоардыг хөгжүүлэхээр ажиллаж байна. | | |
| 4.1.4.2 | Холбогдох нэгж, ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан санал зөвлөмж, хүргүүлж ажилласан байх | Улсын төсөв | Санал зөвлөмж, хүргүүлж ажилласан байх эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан бий болгох анхан шатны системийн үндсэн тодорхойлолтод зөвлөмж хүргүүлэв. Холбогдох нэгж, ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан санал зөвлөмж, хүргүүлэв. | 100 | 100 |
| 4.1.4.3 | Хэрэгцээт тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байх | Улсын төсөв | Хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | Хэрэгцээт тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, тухай бүрд гарсан асуудлыг шийдвэрлэж ажиллав. DME хүрээнд Үнэлгээ мониторингийн газраас зохион байгуулсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт чуулганы үйл ажиллагаанд ажлын хэсэгт шаардлагатай тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав. | 100 | 100 |
| **Стратегийн зорилт 4.2. Засгийн газрын харьяа байгууллагын албан хаагчдыг чадавхжуулж, нэгдсэн удирдлага, зохицуулалттай болсон байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.2.1 Хяналт, үнэлгээ, мониторингийн болон бусад албан хаагчдыг эрсдэлийн удирдлага, процессын дахин инженерчлэл, үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх** | | Улсын төсөв | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | | **100** | **Энэ зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ төлөвлөсөн байна.** | **100** | |
| 4.2.1.1 | Төрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, албан хаагчдыг үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх | Улсын төсөв | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | - | 00-аас доошгүй | 500-аас доошгүй | Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, албан хаагчдыг үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх ажлын хүрээнд үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай хэрэгжүүлсэн Малайз, Солонгос улсад 40 албан хаагчийг, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр яам, аймаг, нийслэлийн төрийн байгууллагад ажилладаг 1042 албан хаагчийг Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг танилцуулах сургалтад хамруулсан. | 100 | 100 |
| 4.2.1.2 | Шинэчлэн баталсан 3 журмыг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, албан хаагчдад | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо<br>-<br>Хамрагдсан албан хаагчийн тоо<br>- | -<br>- | -<br>250-аас | 5<br>250-аас доошгүй | 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ССАЖЯ-ны аймаг, нийслэл дэх спорт, соёл хариуцсан агентлагийн ХШҮ хариуцсан 100 орчим албан хаагчдад шинэ журмын танилцуулга сургалт орсон. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ыг баталж, энэ оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулах сургалт зохион байгуулах | | | | доо шгүй | | холбогдуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Төрийн захиргааны төв байгууллага, яам, агентлаг, 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бодлого төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан албан хаагч нарт зориулан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт сургалтыг Удирдлагын академитай хамтран 2025.05.15,16-ны өдрүүдэд төлөвлөлт, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан 250 орчим албан хаагч нарт зориулан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, оролцогчдод гэрчилгээ гардуулсан.<br>-Нийслэлийн Сүхбаатар, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Засаг даргын харьяа агентлагуудын удирдах болон гүйцэтгэх 120 орчим албан хаагч, ШЕЗ-ийн 40 гаруй албан хаагч, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХ болон сумын ЗДТГ-ын 30 гаруй албан хаагчид оролцсон.<br>-ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллага (Deval)-тай хамтран "Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн бодлогод үнэлгээ хийх" ажлын хүрээнд ажилланггаа суралцах дадлагад суурилсан сургалтыг УИХТГ, ЕТГ, төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээний асуудал хариуцсан албан хаагчдыг оролцуулан 9 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд Мэдээлэл, технологийн үндэсний паркт зохион байгуулсан.<br>-2025.10.30-ны өдөр Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад, 2025.11.19-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан хаагчдад "Үнэлгээ хийх журам"-ын танилцуулга хийсэн. | | |
| 4.2.1.3 | Монгол Улсын хөгжлийн бодлогын чадавхын индексийг тогтоох үнэлгээний дүнг танилцуулах арга хэмжээ зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо<br>- | - | 2 | 2 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны харьяа Хөгжлийн үнэлгээний байгууллага (DEval), Монголын үнэлгээний холбоотой хамтран "Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс" тогтоох үнэлгээний үр дүнг танилцуулах үндэсний чуулганыг Төрийн ордонд 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, яам, Засгийн газрын агентлаг, 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, | 100 | 100 |
| | | | Хамрагдсан албан хаагчийн тоо | - | 250-аас дээш | 250-аас дээш | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | улсын төсөвт үйлдвэрийн газар, олон улсын байгууллага, их, дээд сургууль, төрийн өмчит компани зэрэг судалгаанд хамрагдсан төрийн болон төрийн бус байгууллагын 400 гаруй төлөөлөлд зохион байгуулж, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн хангаж ажилласан. | | |
| 4.2.1.4 | "Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" богино хугацааны цогц сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 5 | 5 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ыг баталж, энэ оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, холбогдох бусад байгууллагын бодлого төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан албан хаагчдад зориулан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт сургалтыг Удирдлагын академитай хамтран 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд яам аймаг нийслэлийн хяналт шинжилгээний чиглэлээр ажилладаг нийт 242 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын зорилго нь дээрх журмууд болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг дүгнэх арга зүйг ойлгож хэрэглэх талаар тодорхой мэдлэг олгож, албан хаагчдын чадавхыг сайжруулахад чиглэсэн бөгөөд сургалтыг тодорхой кейс, даалгавар дээр ажиллах, асуудлыг тодорхойлох, үр дүнгээ хэлэлцэх байдлаар зохион байгуулж, журмын хэрэглээний арга зүйн мэдлэгийг олголоо. Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас сургалтад оролцсон 242 албан хаагчид "Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс тогтоох, хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сэдэвт багц сургалтад хамрагдсаныг баталгаажуулж, сертификат олголоо. | 100 | 100 |
| 4.2.1.5 | Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагыг газар дээр нь судлах | Улсын төсөв | Томилолтын тайлангийн тоо | | 2 | 2 | 1.Ерөнхий Сайдын Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Шуухийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Удирдлагын академи, Хэнтий, Дархан аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, мониторинг, үнэлгээ хариуцсан нийт 20 албан хаагч БНСУ-д | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Гүйцэтгэлийн удирдлага" сэдвийн хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний чиглэлээр сургалтад 2025 оны 3 дугаар сарын 23-29-ний өдрүүдэд хамрагдсан.<br>2.Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж байгаа Малайз Улсад албан томилолтоор ажиллаж, тус улсын Сангийн яам, Бүтээмжийн байгууллага, Пеманду ассоциаци гэсэн байгууллагуудад үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагыг судалсан. | | |
| 4.2.1.6 | Төрийн захиргааны болон төрийн өмчит компаниудад хяналт шалгалтын үр дүнд үндэслэн сургалт зохион байгуулах, харьяа байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 1 | - | 1 | ССАЖЗЯ, ХББОСЯ болон уг яамдын харьяа агентлагуудын албан хаагчдад "Төрийн байгууллагад гарч буй нийтлэг зөрчил, дутагдал, цаашид анхаарах асуудлууд" сэдэвт сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр цахимаар зохион байгуулахаар төлөвлөж, удирдамж, сургалтын сэдвийг боловсруулаад байна. | 70 | 70 |
| | | | Арга хэмжээний тоо | 1 | - | 1 | Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн, өргөдөл гомдол шалгах ажлын хүрээнд Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан 15 байгууллагын дотоод хяналт хариуцсан 39 ажилтны мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн чиглүүлж ажилласан. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.2.2. Хяналт, үнэлгээ, мониторингийн албан хаагчдыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | **100** | **"Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын төслийг тус тус боловсруулан Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд холбогдох аргачлалыг боловсруулж байна.** | **56** | |
| 4.2.2.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг үнэлэх аргачлал боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт хяналт шинжилгээ хийх чиг үүрэг Засгийн газрын тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр ЗГХЭГ-ын чиг үүрэгт шилжсэн бөгөөд, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын 3 дугаар бүлэгт заасан "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх хэсгийг тусгайлан журмаар зохицуулахаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, журамд өөрчлөлт орсон тул аргачлал боловсруулах эрх зүйн үндэслэлгүй болсон. | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2.2 | Хяналт-шинжилгээ хийх аргачлал боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | Хяналт шинжилгээ хийх аргачлалын төсөл боловсруулсан. Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн хуралдаанаар 2025 оны 43 дугаар тогтоолын төслийг хэлэлцүүлэхэд тус тогтоолын 4 дүгээр заалтад байсан Монгол Улсын сайд бөгөөд Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргад аргачлал батлахыг даалгасан заалт нь 2025.04.25-ны өдөр албажиж гарахдаа хасагдсан байсан тул, аргачлал батлах эрх зүйн үндэслэлгүй болсон. | 80 | 80 |
| 4.2.2.3 | "Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ хийх аргачлал боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | "Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ хийх аргачлал боловсруулах ажилд хамтарч ажиллах ажлын хүрээнд эхний шатны судалгааг хийн аргачлалын төслийг боловсруулан ажиллаж байна. Аргачлалын төслийг боловсруулахдаа дараах эх сурвалжуудыг ашиглалаа. Үүнд: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.01.20-ны өдрийн А/08 дугаар "Аргачлал, загвар батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралт "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал", Үндэсний хөгжлийн газрын даргын 2020.06.18-ны өдрийн А/56 тоот тушаалын 4 дүгээр хавсралт "Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал", Paul Stricker-ийн "Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаанд ашиглагдах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд (Key Performance Indicators in FDI Attraction)" | 50 | 50 |
| 4.2.2.4 | Урьдчилсан үнэлгээ хийх жишиг аргачлал боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулсан "Үнэлгээний удирдамж", Америкийн Улаан загалмай нийгэмлэг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг хамтран боловсруулсан "Үнэлгээнд бэлтгэх" (Урьдчилсан үнэлгээний төлөвлөлтийн удирдамж ба хэрэгслүүд) гарын авлага зэрэг гадаад, дотоодын урьдчилсан үнэлгээний талаар эх сурвалжуудыг харьцуулан судалж, аргачлалын төсөл боловсруулсан. | 70 | 70 |
| 4.2.2.5 | Явцын үнэлгээ хийх жишиг аргачлал, боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | 1.Аргачлал боловсруулахад шаардлагатай нэмэлт материал судалсан. Коста-Рика Улс, JICA-ийн үнэлгээний аргачлалын талаар холбогдох материал судалж, явцын үнэлгээ хийх аргачлалын эхний төслийг боловсруулаад байна.<br>2.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бие даасан үнэлгээний газартай хамтран боловсруулсан НҮБХХ-ийн үнэлгээний заавар, Япон улсын JICA байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүгийн стандарт үзүүлэлтийн лавлагаа, Америкийн Үнэлгээний холбоо зэрэг олон улсын байгууллагын | 40 | 40 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээний баримт бичгүүдтэй танилцаж, холбогдох арга зүйг судалсан. Эдгээрт тулгуурлан явцын үнэлгээ хийх жишиг аргачлалын төслийг боловсруулж, Үр дүнгийн шинжилгээний хэлтсийн хурлаар хэлэлцүүлэв. | | |
| 4.2.2.6 | Эцсийн үнэлгээ хийх жишиг аргачлал боловсруулах | Улсын төсөв | Боловсруулсан, батлуулсан аргачлалын тоо | - | - | 1 | Энэ аргачлалын төслийн боловсруулахаар Солонгос улсын үнэлгээний аргачлалын талаар, НҮБ үнэлгээний багийн туршлага судалж эхний төсөл боловсруулагдсан бөгөөд хэлтсийн хэмжээнд урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. | 40 | 40 |
| **Стратегийн зорилт 4.3. Мэдлэг, инновац, технологид суурилсан байгууллагын өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.1 Байгууллагад эерэг, бүтээлч, ногоон дадал бүхий соёлыг төлөвшүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | **4** | Энэ зорилтын хүрээнд нийт 3 арга хэмжээ төлөвлөсөн ба байгууллагын стратеги төлөвлөгөөнд туссаны дагуу 2029 онд бүрэн хэрэгжих юм. | | |
| **4.3.1.1** | Байгууллагын ажлын орчны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах "5S хөтөлбөр"-ийг эхлүүлэх | Улсын төсөв | Ажлын хэсгийн тушаал гарсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | Төрийн байгууллагад холбогдох стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр "Креатив даймонд" ХХ-д хүсэлт хүргүүлж, судалгаа хийлгэсэн бөгөөд анхны үнэлгээ, орчны судалгаагаар байгууллагын орчны цэвэр байдал 55%, цэвэрлэгээ тогтмол бус, зохион байгуулалт 40%, баримт бичгийн цэгц 60%, харилцаа хамтын ажиллагаа 70% байгааг тус тус 90% -т хүргэх зорилт тавин ажилласны үр дүнд байгууллагын цэвэр байдал 30%, албан хаагчдын хариуцлага 20%, сэтгэл ханамж 19% нэмэгдсэн байна. Байгууллагын санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан уг компанитай захиалгаар хийлгэхээр төлөвлөсөн ажлын гэрээ байгуулаагүй. Байгууллагын ажлын орчны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах "5S хөтөлбөр"-ийг эхлүүлбэл албан хаагчдын сэтгэл ханамж 19%-иар нэмэгдэх боломжтой судалгаа гарсан тул байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор дээрх зорилтыг тавин ажилласан боловч байгууллагын санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан уг компанитай захиалгаар хийлгэхээр төлөвлөсөн ажлын гэрээ байгуулаагүй. | 100 | 60 |
| | | | Ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | | | |
| | | | Албан хаагчдад зориулсан сургалт(тоо) | - | - | 1 | | | |
| **4.3.1.2** | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Сайн санааны хөтөлбөр"- | Улсын төсөв | Сайн санаалын хөтөлбөрийн төсөл (тоо) | - | - | 1 | Төлөвлөгөөнөөс хасуулах саналтай. "Сайн санаалын хөтөлбөр" нь байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, ISO стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай цогцоор хийгдэх тул энэ жилийн төлөвлөгөөнөөс хасуулах саналыг гаргаж байна. | - | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн төсөл боловсруулах | | | | | | | | |
| 4.3.1.3 | Албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгаа хийх, дүнг удирдлагад танилцуулах, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Судалгааны тайлан (тоо)<br><br>Шийдвэрлэсэн арга хэмжээ (тоо) | - | - | 1 | Байгууллагын ажлын орчны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах "5S хөтөлбөр"-ийг эхлүүлэхтэй холбоотойгоор албан хаагчдын сэтгэл ханамж 19% нэмэгдэх боломжтой. | 100 | 70 |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.2 Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэх** | | **Улсын төсөв** | **Төлөвлөгөөний хэрэгжилт (хувь)** | **-** | **-** | **100** | **Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.** | **100** | |
| 4.3.2.1 | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Улсын төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилт (хувь) | - | 90 | 100 | -2025 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 46 албан хаагчид 43,5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.<br>-Төрийн албанд анх томилогдож, шаардлага хангасан 8 албан хаагчаар төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлж ажиллав.<br>-Албан хаагчийн гаргасан хүсэлтийг үндэслэн 17 албан хаагчид цалинтай чөлөө, 9 албан хаагчид цалингүй чөлөө олгож, 22 албан хаагчид цалингийн нэмэгдлийг тус тус олгосон.<br>-Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт үр бүтээлтэй ажилласан 12 албан хаагчийг төрийн дээд одон медалиар шагнуулах хүсэлтийг 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/269 дугаар албан бичгээр хүргүүлж, 9 албан хаагчид төрийн дээд одон медаль гардуулсан.<br>-Эрүүл мэндийн яаманд байгууллагын төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах хүсэлт илгээж, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Улсын хоёрдугаар нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгууллаа. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран байгууллагын 110 албан хаагчийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулаа.<br>-Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран хүсэлт гаргасан 76 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулав | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.3. ISO9001:2015 Олон улсын чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэх** | | **Улсын төсөв** | Бэлтгэл ажлын төлөвлөгөөний төсөл (Тоо) | | - | 1 | Төрийн байгууллагад холбогдох стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг "Менежмент ба ур чадварын хүрээлэн"-д хүсэлт хүргүүлж, байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан эхний ээлжид **ISO9001:2015 Олон улсын чанарын удирдлагын нэгдсэн тогтолцооны нэг багц болох** "Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (ISO37001:2016) стандартын хүрээнд "Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн зөрүүгийн шинжилгээ"-г боловсруулахад хамтран ажиллахаар тохиролцсон. Уг стандартын зөрүүгийн шинжилгээг бодит, нотолгоонд тулгуурлан 1.Баримт бичгийн шинжилгээ, 2.Асуумж ба ярилцлага, 3.Байгууллагын орчны ажиглалт гэсэн судалгааны үндсэн 3 аргачлалыг ашиглан зөрүүгийн шинжилгээг эхлүүлэн ажиллаж байна. Байгууллагын санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан уг компанитай захиалгаар хийлгэхээр төлөвлөсөн ажлын гэрээ байгуулаагүй. | **100** | |
| **4.3.3.1.** | Стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг судлах, холбогдох зардлыг 2026 оны төсөвт суулгах | Улсын төсөв | Төсөвт санал өгсөн эсэх (Тийм-1 Үгүй-0) | - | 1 | 1 | Стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг "Менежмент ба ур чадварын хүрээлэн", "Креатив даймонд" ХХК-уудтай хамтран ажиллахаар тохиролцоод байна.<br>2026 оны төсөвт холбогдох зардлыг тусгуулахаар төсөв, худалдан авалт хариуцсан албан хаагчид санал хүргүүлсэн. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.4 Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг урт болон дунд хугацааны зорилго, зорилттой уялдуулан өргөжүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | **100** | **Монгол хуульчдын холбоотой хамтран ажиллах хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Монголын Үндэсний үнэлгээний холбоотой хамтарч ажиллаад байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргаар ахлуулсан төлөөлөгчид Бүгд Найрамдах Франц Улсын Аудитын шүүх, Испанийн хаант улсын Аудитын шүүхэд тус тус ажлын айлчлал хийж харилцаа тогтоож ажиллав.** | **100** | |
| 4.3.4.1 | Төрийн болон төрийн бус, олон нийтийн | Улсын төсөв | Хамтран ажиллах санамж бичиг, гэрээ | - | **1** | **2** | Монгол хуульчдын холбоотой хамтран ажиллах хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай хамтран ажиллах | | (тоо) | | | | Монголын Үндэсний үнэлгээний холбоотой хамтарч ажиллаж байна. | | |
| 4.3.4.2 | Гадаад улс, олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | Улсын төсөв | Хамтран ажиллах санамж бичиг, гэрээ (тоо) | | 1 | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргаар ахлуулсан төлөөлөгчид Бүгд Найрамдах Франц Улсын Аудитын шүүх, Испанийн хаант улсын Аудитын шүүхэд тус тус ажлын айлчлал хийж харилцаа тогтоов.<br>Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газар; Америк, Ойрх Дорнод, Далайн орнуудын газар, Европ, Африкийн газар, Азийн газар, Олон талт хамтын ажиллагааны газрын захирлуудтай ганцаарчилсан цуврал уулзалтууд хийж санал солилцож, хамтран ажиллах талаар тохиролцсон.<br>Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний нөөцийн хөгжлийн хүрээлэн (National Human Resources Development Institute) болон Солонгосын төрийн захиргааны хүрээлэн (Korean Institute of Public Administration)-тэй тус тус харилцаа тогтоон хамтран ажиллах эхлэлийг тавьсан.Германы Эдийн засгийн яамны харьяа Судалгааны хүрээлэн (DEval)-тэй харилцаа тогтоож, хамтын ажиллагаа эхлүүлсэн. Тус хүрээлэнтэй 2025, 2026 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрт хамтран үнэлгээ хийх, үнэлгээ, мониторингийн чиглэлээр сургалт зохион байгуулах, ЗГХХГ-ын төлөөлөгчдийг олон улсын хурал, семинарт оролцуулахаар тус тус тохиров. 2025 оны 9 дүгээр сард тус хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран Улаанбаатар хотноо 2 өдрийн сургалт-семинар зохион байгуулав.<br>Канадын Олон улсын хөгжлийн буцалтгүй тусламжийн санхүүжилттэй МЕРИТ-2 төслийн хүрээнд 2025-2030 онд 20 гаруй чиглэлээр сургалт зохион байгуулахаар харилцан тохиролцов.<br>ХБНГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллагын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж хамтран ажиллаж тус байгууллагатай байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулах, Гадаад харилцааны яамаар хянуулах, санамж бичгийг байгуулах ажлыг зохион байгуулсан.<br>2025 онд гадаад томилолтын зардалд 39,869,928 төгрөгийн төсвийг зарцуулсан байна. | 100 | 100 |
| 4.3.4.3 | Хяналт шалгалтын чиглэлээр гадаад | Улсын төсөв | Сургалтын тоо | - | - | 1 | БНСУ-ын нийслэл Сеүл хотод 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтын ажиллагааны хүрээнд албан хаагчдыг холбогдох чиглэлээр мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах | | | | | | албан хаагчдад зориулсан "Хүртээмжтэй манлайлал" сургалтад 4 албан хаагч, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.2.3.2 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын төлөөлөгчид Малайзын Улсын нийслэл Куала Лумпур хотод 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 21-ний өдрүүдэд тус улсын Сангийн яам, Бүтээмжийн байгууллага, Pumandu ассоциаци зэрэг байгууллагуудад үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагыг судлах сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан. | | |
| 4.3.4.4 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хөгжлийн үнэлгээний институттэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах | Улсын төсөв | Байгуулсан санамж бичиг | - | - | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь БНГУ-ын Үнэлгээний хөгжлийн байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг 2025.07.04 өдөр гарын үсэг зурсан ба ГХЯ-ны байгууллага хоорондын гэрээний бүртгэлийн "2025 07/07" дугаарт бүртгүүлсэн болно.<br>Санамж бичгийн хэрэгжилтийг хангуулах 2025 оны 9 дүгээр сараас 2026 оны 12 дугаар сар хүртэл хугацааны нарийвчилсан төлөвлөгөөг батлуулахаар 2 тал харилцаж байна. | 100 | 100 |
| 4.3.4.5 | Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллана. | ОУБ-ын төсөв | Төсөл хөтөлбөрийн тоо | - | 1 | 1 | 1.Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгын хүрээнд Санхүү, эдийн засгийн дээд сургуультай хамтран Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцооны өнөөгийн байдлын талаар суурь судалгаа хийсэн. "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг" боловсруулж, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан.<br>2.Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн төлөөлөлтэй уулзах ажлын хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Байгаль хамгааллын захирал Б.Чимэддоржтой 02 дугаар сарын 12-ны өдөр, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтыг шинэчлэн ахиулах (NDC 3.0), Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн зохицуулагч Н.Жавхлантай 02 дугаар сарын 13-ны өдөр, TNC Байгаль хамгааллын байгууллагын Байгаль хамгааллын захирал н.Баяржаргалтай 02 дугаар сарын 14-ний өдөр хийсэн ярилцлагад тус тус оролцож | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын эрсдэлийг бүртгэж, үнэлэн ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>3.Мөн олон улсын байгууллагуудтай уулзалт товлож, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй ажлын уулзалт зохион байгуулж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон. Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн "Интегра" тэтгэлэгт хөтөлбөрт "Уул уурхай, эрдэс баялгийн салбарын төрийн өмчит компаниудын худалдан авалтын үйл ажиллагааны ил тод, шударга, авилгаас ангид байдлыг дээшлүүлэх арга замууд" сэдэвт нийт 35 сая төгрөгийн төслийн саналыг боловсруулж хүргүүлсэн. | | |
| 4.3.4.6 | Процессын дахин инженерчлэлийг хийх аргачлал, гарын авлагыг ашиглах, хэрэгжүүлэх чиглэлээр хүний нөөц бэлтгэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | Улсын төсөв | Хэлэлцүүлэг, сургалт (тоо) | - | - | 1 | Нийт 2 удаагийн хэлэлцүүлэг, 6 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>-БОУАӨЯ түүний харьяа Ойн газарт хэрэгжүүлж буй Процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр салбарын судалгааны байгууллагуудтай, 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр салбарын удирдлагуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.<br>-Цагдаагийн Ерөнхий газарт ПДИ-ийн судалгаа, шинжилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой ПДИ-ын баримт бичгийн төсөлд туссан арга, аргачлалыг хэрхэн хийх хэрэгжүүлэх, ПДИ-ийн ойлголт, Процессын шинжилгээ, КЭЙЗЕН арга болон олон улсад хэрэглэгдэж байгаа асуудал тодорхойлох, асуудлын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг авах ПАРЕТО, ИШИГАВА, РҮҮТ КАУС анализ, 5 WHY, 5W1H, 5S зэрэг аргуудыг талаар сургалтын ЦЕГ-ын 60 гаруй албан хаагчдад, 2025 оны 05-р сарын 1, 2-нд Ховд, Өвөрхангай, Баянхонгор аймгийн алба хаагчдад, 2025 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж, танхимаар 150, цахимаар 37 алба хаагчдыг хамруулан ПДИ талаар ойлголтыг түгээж ажилласан.<br>-Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитай хамтарч Ёс зүйн хорооны ажлын алба болон Удирдлагын академийн 40 орчим албан хаагчдад "Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой чиг үүрэг болон процесс зураглал хийх, ПДИ талаар ойлголтыг өгч, судалгааны арга зүй"-г хэрхэн ашиглах талаар чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>-Хүний эрхийн үндэсний комисстой байгуулсан гэрээний үндсэнд 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион "Хүний эрх ба төрийн бүтээмж хамтарсан сургалтад Төрийн байгууллагад хэрэгжүүлсэн ПДИ-ийн судалгааны арга, | 100 | 75 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аргачлал, олж мэдсэн туршлага" сэдвээр 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комиссын 25 албан хаагчийг хамруулан ПДИ талаар ойлголтыг түгээж ажилласан. | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.5 Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, төлөвшүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | 100 | **Энэ зорилтын хүрээнд нийт 3 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 2 арга хэмжээ байна.** | **ХБ** | |
| 4.3.5.2 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна. | Улсын төсөв | Сургалтын (тоо) | - | 1 | 1 | Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:<br>1.Байгууллагын албан хаагчдын эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор газар, хэлтсийн 25 албан хаагчийг хамруулан 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр;<br>2.Цагдаагийн газарт хийгдэж буй процессын дахин инженерчлэлийн хүрээнд эрсдэлийн шинжилгээний ажлын хэсгийн гишүүдэд эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр;<br>3.Дархан -Уул аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргаас 2025 оны 148 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус газрын 10 албан хаагчдад Төрийн байгууллагын бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх, Эрсдэл, эрсдэлийн менежментийн тогтолцоо, эрсдэлийн удирдлагын үйл явц, хяналтын тогтолцооны талаарх ойлголт мэдлэгийг бэхжүүлэх;<br>4.Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн албаны даргаас 2025 оны 11/18689 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус албаны 50 гаруй албан хаагчдыг хамруулан 4 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>Сургалтыг эрсдэлийн удирдлагын менежмент, эрсдэлийн засаглал ба соёлыг төлөвшүүлэх, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх агуулгын хүрээнд зохион байгуулсан. | 100 | 100 |
| **5. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | 100 | **Нийт 17 арга хэмжээ төлөвлөж, тайлант хугацаанд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.1 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хууль бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, газар, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах | Улсын төсөв | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө (тоо) | 1 | 1 | 1 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу боловсруулж, 2025.01.15-ны дотор бүтцийн бүх нэгж, нийт албан хаагчдын гүйцэтгэлтийн төлөвлөгөөг батлуулсан. Мөн байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/30 тоот тушаалын дагуу ажлын хэсэгт 14 албан хаагч ажиллаж, Монгол Улсын сайд, ХҮҮХ-ны даргын 2025.04.22-ны өдрийн А/19 тоот тушаалаар "ЗГХХГ-ын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-г батлуулав. Үүнтэй холбоотой байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зохих нэмэлт өөрчлөлтийг тусгаж, шинэчлэн батлуулав. | 100 | 100 |
| | | | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө (тоо) | 6 | 7 | 7 | Стратеги төлөвлөгөө батлагдсантай холбоотой бүтцийн нэгжүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зохих нэмэлт тодотголыг хийж, 7 газар, 8 хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөтэй уялдуулан /2025.04.28-ны өдөр/ шинэчлэн баталсан. | 100 | 100 |
| 5.1.2 | Байгууллага болон газар, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнах | Улсын төсөв | Байгууллагын гүйцэтгэлийн тайлан | - | 1 | 2 | Байгууллагын хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж, ДХАГ-т шилжүүлэв. | 100 | 100 |
| | | | Нэгжийн гүйцэтгэлийн тайлан | - | 7 | 14 | Газар, нэгжүүд эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, Тамгын газарт хүргүүлж ажиллав. | 100 | 100 |
| 5.1.3 | Газар нэгж, албан хаагчдын улирал, хагас жил, бүтэн жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг зохих журмын дагуу үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Үнэлгээний хорооны ажлын тайлан | - | 1 | 2 | Газар, хэлтэс, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үр дүнг улирал, хагас жилээр хүлээн авч, ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал"-ын дагуу "Үнэлгээний хороо" байгуулагдаж, журам зааврын дагуу үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулж, ажиллав. | 100 | 100 |
| 5.1.4 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан Засгийн газрын шийдвэрийн төслийг хянах | Улсын төсөв | Хянуулахаар ирүүлсэн шийдвэрийн төслүүдээс хянагдсан хувь | - | 100 | 100 | ЗГХХГ-аас боловсруулсан дор дурдсан Засгийн газрын шийдвэрийн төслийг хянаж, ЗГХЭГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулсан:<br>2024 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;<br>Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны үнэлгээний тайлан; | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024 онд иргэдээс захиргааны байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан;<br>Нийслэлийн дэд бүтцийг дэмжих шуурхай штабын ажлын явц, холбогдох шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл;<br>"Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын төсөл.<br>Мөн дээрх танилцуулах асуудлын тэмдэглэлийн төсөл, танилцуулга, сайдын хэлэх үг зэргийг ҮМГ, ТСБТГ-тай хамтран боловсруулж, хянасны үндсэн дээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна. | | |
| 5.1.5 | Бусад яамдаас Засгийн газрын шийдвэрийн төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичигт хариу төлөвлөх, санал боловсруулах | Улсын төсөв | Санал авахаар ирүүлсэн албан бичгүүдэд хариу хүргүүлсэн (хувь) | 97 | - | 100 | Бусад яамдаас ЗГ-ын шийдвэрийн төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичигт 118 санал боловсруулж хүргүүлсэн. | 100 | 100 |
| 5.1.6 | Хуулиар харьяалуулсан чиг үүрэгтэй холбоотой байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг бүртгэж, холбогдох шийдвэрт хууль, эрх зүйн дүгнэлт хийх | Улсын төсөв | Арга хэмжээний биелэлт (хувь) | - | 100 | 100 | -МУИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулиас ЗГХХГ-т холбогдуулан гаргасан захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар гаргасан. Шүүх хуралдаанд хариуцагчийг төлөөлөн оролцсон. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br><br>-Уур амьсгалын өөрчлөлт, орчны судалгааны төвийн ЗГХХГ-т холбогдуулан гаргасан "албан шаардлагыг хүчингүй болгуулах" нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцсон. Уг нэхэмжлэлтэй холбоотой хяналт шалгалтын холбогдох албан хаагчдад хууль зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажилласан. Захиргааны хэргийн анхан шатны хурал 3 удаа хойшлогдож, анхан шатны шүүхээс 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэхэмжлэгчийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Тамгын газраас боловсруулан ирүүлсэн "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам", "Албан хаагчдыг зайнаас цахим хэлбэрээр ажиллуулах журам", "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам", "Сургалтын хөтөлбөр батлах тухай" журмын төслийг хянаж, санал боловсруулж хүргүүлсэн. "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын төслийг хянасан.<br><br>-Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой бусад газруудаас боловсруулсан тушаалын төслийг тухай бүр хянасан.<br><br>-ЗГХХГ-ын даргад хандан нэхэмжлэл гаргасан захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож, нэхэмжлэлийн хариу тайлбарыг шүүхэд хүргүүлж, урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон. | | |
| 5.1.7 | Хяналт шалгалт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үр дүнд үндэслэн хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журам, стандартыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх. | Улсын төсөв | Хүргүүлсэн санал (хувь) | | | - | 100 | ЗГХХГ-аас 2025 оны I, II улиралд гүйцэтгэсэн хяналт шалгалт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгаа, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад илэрсэн хууль тогтоомж, бодлого, шийдвэр, дүрэм, журам, стандартыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой мэдээллийг байгууллагын бусад нэгжүүдээс дотоод албан бичгээр авч, нэгтгэсэн.<br>ЗГХХГ-аас гүйцэтгэсэн дээрх ажлын үр дүнд үндэслэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын боловсронгуй болгох талаар судалгаа хийж байна.<br>2025 оны I, II, III улирлын байдлаар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг боловсронгуй болгохтой холбоотой дараах саналуудыг гаргасан:<br>- Засгийн газрын 2012 оны Хилийн заагийг тогтоох тухай 194 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Ойн сан бүхий газрын хилийн зааг"-т өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг батлах эрх зүйн үндэслэлд өөрчлөлт орсон тул журмыг шинэчлэн баталж, холбогдох зохицуулалтыг хуульд нийцүүлж, боловсронгуй болгох;<br>- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах Улсын Их Хурал дахь ажлын | ХБ | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсэгт хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын шалгуур, олон улсын туршлагатай холбоотой судалгаа;<br>- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газарт хийсэн ПДИ-ийн ажлын хүрээнд салбарын зарим хэм хэмжээний актын зохицуулалтыг хуульд нийцүүлэх, боловсронгуй болгох;<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргаас батлах хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлж, шинэчлэн батлах;<br>- "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын холбогдох зохицуулалтыг хуульд нийцүүлж, боловсронгуй болгож, шинэчлэн батлах;<br>Төрийн албаны тухай хуулийн зарим зохицуулалт болон "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын зохицуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой санал; | | |
| 5.1.8 | Албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, эрэлт хэрэгцээнд үндэслэн холбогдох чиглэлээр сургалт, семинарт хамруулж, мэргэшүүлэх | Улсын төсөв | Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь | - | 90-ээс доошгүй | 100 | -Албан хаагчдыг мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор БНСУ-д 12, Япон Улсад 1, Латви Улсад 1 албан хаагч сургалтад хамрагдсан байна.<br>-Удирдлагын академийн төрийн албан хаагчийн Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 6, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 10, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6, боловсролын удирдлага, удирдлагын менежментийн чиглэлээр докторын сургалтад 2, бусад сургалтад 46 буюу давхардсан тоогоор нийт 90 албан хаагчдыг сургалтад хамрууллаа.<br>**УМГ:1.**БНСУ-ын Хүний нөөцийн хөгжлийн институтээс зохион байгуулсан сургалтад "Гүйцэтгэлийн удирдлага" сэдвийн хүрээнд тус газрын 3 албан хаагч 2025 оны 3 дугаар сарын 23-29-ний өдрүүдэд хамрагдаж, сертификат авсан.<br>**2.**Удирдлагын академиас зохион байгуулж буй "Төрийн бодлого, бодлогын шинжилгээ" танхимын сургалтад тус газрын 2 албан хаагч хамрагдаж, сертификат авсан.<br>**3.**БНСУ-д зохион байгуулагдсан "Хүртээмжтэй манлайлал" сэдэвт сургалтад газрын 1 албан хаагч 2025 оны 02 дугаар | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 10-ны өдрөөс 14-ны өдрүүдэд хамрагдаж гэрчилгээ авсан.<br>**4.**ЗГХХГ-аас ХБНХГУ-ын Хөгжлийн үнэлгээний байгууллагатай хамтран зохион байгуулсан "Бодлогын үнэлгээний төлөвлөгөө боловсруулах үе шат" сэдэвт сургалтад хамрагдсан.<br>**5**. 2025 оны 11 дүгээр сарын 25, 28-ны өдрүүдэд "Скай Фист" ХХК-аас зохион байгуулсан "Өгөгдөлд суурилсан цахим засаглал ба мэдээлэл технологийн менежментийн чадавхыг сайжруулах" сэдэвт сургалтад хамрагдаж SF2025093 дугаар бүхий батламж авсан.<br>**6.**Мониторинг үнэлгээний цогц ойлголт, кейс ажиллагаа сэдэвт сургалтад газрын 14 албан хаагч хамрагдлаа.<br>**ХЭЗГ:** УА-аас зохион байгуулсан Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах сургалтад хамрагдсан.<br><br>-Монголын хуульчдын холбоо болон АТГ-аас зохион байгуулсан "Дүрэм, журам боловсруулах арга зүй", "Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт", "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" сэдэвт сургалтад ЗГХХГазрын 50 гаруй албан хаагч 2025.05.28-ны өдөр хамрагдсан.<br><br>-ҮМГ болон Deval олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын үнэлгээ" сэдэвт сургалтад 2025.05.21-2025.05.24-ний өдрүүдэд 5 албан хаагч хамрагдсан.<br><br>-Мониторинг, үнэлгээний цогц ойлголт, кейс ажиллагаа сэдэвт сургалтад 2025 оны 12 сарын 05 өдөр хамрагдсан.<br><br>-Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад хамрагдсан.<br><br>-Тагнуулын Ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас цахимаар Кибер аюулгүй байдлын тухай хууль, журмын тухай сургалтад 12 дугаар 03-ны өдөр хамрагдсан.<br><br>-Нийслэлийн онцгой байдлын газраас төрийн байгууллагын ажилтнуудын онцгой нөхцөл байдал, гамшгийн үед ажиллах чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах мэдлэг олгох, байгууллагын дотоод бэлэн байдлыг хангах талаарх сургалтад хамрагдсан. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УА-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдаж, сертификат авсан. | | |
| 5.1.9 | Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Зэрэг дэв олгогдсон албан хаагч (тоо) | 28 | 43 | 43 | Төрийн захиргааны албан тушаалын ахлах, дэс түшмэлийн ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг хангасан нийт 43 албан хаагчид Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар ахлах түшмэлийн болон дэс түшмэлийн зэрэг дэв олгосон.<br>Шаардлага хангасан 10 албан хаагчид төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг олгуулах хүсэлтийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/136 дугаар албан бичгээр хүргүүлснээс Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 100 дугаар захирамжаар 7 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг олгуулсан байна. | 100 | 100 |
| 5.1.10 | Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах | Улсын төсөв | Батлагдсан АТТ (тоо) | 28 | - | 80 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/18 дугаар тушаал гарсантай холбогдуулан "Албан тушаалын тодорхойлолт"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 2025 оны А/29 дүгээр тушаалаар байгуулан, 31 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинээр, 40 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах нийт 71 албан тушаалын тодорхойлолтыг батлуулах зөвшөөрөл хүсэх хүсэлтийн Төрийн албаны зөвлөлд 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/319 дугаар албан бичгээр хүргүүлж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 71 албан тушаалын тодорхойлолтыг батлуулллаа. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 125 дугаар тушаалаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан зарим албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, шинээр батлуулах шаардлага үүсэж, Төрийн албаны зөвлөлд 2025 оны 09 сарын 16-ны өдрийн 01/931 дүгээр албан бичгээр хүсэлт хүргүүлж ажиллав. | 100 | 88 |
| 5.1.11 | Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах албан хаагчидтай | Улсын төсөв | Байгуулсан хөдөлмөрийн гэрээ | 15 | - | 100 | Төрийн үйлчилгээний албан хаагч болон гэрээт ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, давхардсан тоогоор төрийн үйлчилгээний 35 ажилтан, гэрээт | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн гэрээ, байгуулах, гэрээний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах | | (хувь) | | | | 14 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгууллаа. Тайлант хугацаанд 7 гэрээт ажилтны гэрээний хугацааг өөрийн хүсэлт, гэрээний хэрэгжилтийг харгалзан дуусгавар болгож, албан хаагчтай хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох ажил хүлээлцэх, гэрээний хэрэгжилтийн тайланг хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллав. | | |
| 5.1.12 | Байгууллагын сул орон тоог хуульд заасны дагуу нөхөх, төрийн албаны сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулах | Улсын төсөв | Томилогдсон албан хаагч (тоо) | 115 | - | 140 | Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5 дахь хэсэгт заасны дагуу төрийн бусад байгууллагаас болон байгууллагын нэгж хооронд 26 албан хаагчийг шилжүүлэн томилсон, төрийн албаны нөөцөд байгаа 34 иргэнээр төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөж, 38 албан хаагчийг албан тушаалаас нь чөлөөлж, 8 гэрээт (судлаач, шинжээч, зөвлөх)-ийг томилж, 7 гэрээт ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон байна. Мөн 5 гэрээт (судлаач, шинжээч, зөвлөх)-ийн хугацааг сунгаж, хувийн чөлөө олгох 24 тушаал, бүтцийн тушаал 2, зэрэг дэвийн олгох тухай тушаал 2-ыг боловсруулан баталгаажуулсан байна.<br>2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 6 удирдах албан тушаалын, 13 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлан, Төрийн албаны зөвлөлийн болон Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор 3 удирдах албан тушаалтан, 12 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөж ажиллав | 100 | 100 |
| 5.1.13 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэх. | Улсын төсөв | ХАСУМ, ХОМ-тэй холбоотой зөрчил гарсан эсэх (тийм-1, үгүй-0) | - | 0 | 0 | Тус газрын албан хаагчид ХАСХОМ хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.14 | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, (Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга) байгууллагын удирдлагыг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэргэшлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | 100 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Итгэмжлэлийн төвийн удирдлага, албан хаагчидтай тодорхой чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг цаг тухайд нь хүргүүлсэн.<br>Сайдын ажлын албанд өдөр тутмын 126 мэдээг нэгтгэн хүргүүлсэн.<br>Байгууллагын даргыг мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулалтын нэгжүүдээс тухай сард гүйцэтгэх онцлох ажлын мэдээллийг авч нэгтгэн, сар тутам хуанли хийх бэлтгэлийг хангаж ажиллаж байна.<br>Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга, Хяналт хэрэгжүүлэх газрын удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулалтын нэгжүүдээс өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг авч нэгтэн танилцуулж байна.<br>Байгууллагын удирдлагын УИХ-ын гишүүдтэй хийх 3 удаагийн уулзалтын бэлтгэлийг хангаж ажиллав. | 100 | 100 |
| 5.1.15 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын "Дотоод хяналтын нийтлэг журам" боловсруулж, батлуулах | Улсын төсөв | Батлагдсан журам (тоо) | - | 1 | 1 | -ЗГХХГ-ын ДХАГ-ын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын төслийг газрын албан хаагчид хэлэлцэн боловсруулж газруудаас санал авч нэгтгэн эцсийн байдлаар удирдлагуудад танилцуулан ЗГХХГ-ын ДХАГ-ын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын төслийг Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын 2025.02.08-ны өдрийн А/08 тоот тушаалаар батлуулсан. | 100 | 100 |
| 5.1.16 | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын тамгын газартай харилцах, хамтран ажиллах | Улсын төсөв | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | - | 4 | 4 | -Эрүүл мэндийн яаманд байгууллагын төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах хүсэлт илгээж, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Улсын хоёрдугаар нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах болов.<br>-Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Чингэлтэй дүүргийн 9 дүгээр цэцэрлэгт хүсэлт хүргүүлсэн.<br>-Баянхонгор, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын дарга нарт цаг үеийн асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажиллав.<br>-Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга нарын чат групп нээж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, зарыг цаг алдалгүй шуурхай хүргэж байв.<br>-Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс, сумдын ХШҮ-ний асуудал хариуцсан албан хаагчдад | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Төрийн албан хэрэг хөтлөлтийн талаар анхаарах асуудал" сэдвээр хичээл заасан.<br>-Эрүүл мэндийн яаманд хүсэлт хүргүүлж, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран 9 дүгээр сарын 30-ны өдөр байгууллагын албан хаагчдыг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулсан.<br>-"Улаанбаатар хотын Хөгжлийн корпораци" ХК-ын гүйцэтгэх захирал Ж.Сандагсүрэнтэй уулзаж, байгууллагын орчны тохижилт, авто зогсоолын талаар хүсэлт хүргүүлж ажиллав. | | |
| 5.1.17 | Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Хууль тогтоомжийн хэрэгжилт (хувь) | - | 100 | 100 | Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийн "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" 32 цагийн анхан шатны хөтөлбөрт 3 албан хаагчийг хамруулж үнэмлэх авсан.<br>Ёс зүйн нөлөөллийн үйл ажиллагааны талаарх албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа авах хугацаа болоогүй.<br>Тайлант хугацаанд төрийн захиргааны 88 албан хаагчийн 2024 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тайлагнаж, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/286 дугаар албан бичгээр тайланг хүргүүлж ажиллав.<br>Албан тушаал шатлан дэвших болон шинээр томилогдох хүсэлт гаргасан 55 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, холбогдох томилгоог хийж ажиллав. | 100 | 100 |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.2 Байгууллагын өдөр тутмын хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, архив, албан хэргийг хөтлөх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | **-** | **-** | **100** | **Энэ зорилтын хүрээнд нийт 16 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 2 арга хэмжээ байна.** | **100** | |
| 5.2.1 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг | Улсын төсөв | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (хувь) 100 | 100 | 100 | 100 | ҮМГ:Тайлант хугацаанд тус газарт нийт **442** албан бичиг хүлээн авснаас **41** албан бичиг хариутай бичиг байсан ба холбогдох асуудлыг судалж шийдвэрлэн, хариуг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан. Мөн бусад нэгжүүдээс ирүүлсэн дотоод албан бичиг **59** хүлээн авсан бөгөөд холбогдох асуудлыг судалж шийдвэрлэн, хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 100 | 90 |
| | | | Хугацаандаа архивд хүлээлгэн өгсөн | - | 1 | 1 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | архивлаж, архивд хүлээлгэн өгөх. | | эсэх (тийм-1, үгүй-0) | | | | 2024 оны хариутай, хариугүй албан бичиг болон бусад баримт бичгүүдийг архивын нэгж үүсгэн архивд бүрэн хүлээлгэж өгсөн болно.<br>ТСБТГ:Байгууллагын дотоод нэгжээс хууль, тогтоол, шийдвэрийн төсөлд санал авахаар ирүүлсэн нийт 59 дотоод албан бичигт холбогдох хугацаанд хариу өгч, бүрэн шийдвэрлэсэн байна.<br>Тайлант хугацаанд тус газар нийт 292 албан бичиг бичиг хүлээн авснаас 259 хариугүй, хариутай 33 албан бичиг, хүлээн авч шийдвэрлэн ажилласан байна. Хугацаа хэтэрсэн албан бичиг, өргөдөл, гомдол байхгүй, хугацаанд зохих хариу өгч, бүртгэлжүүлэн шийдвэрлэсэн болно.<br>Үр дүнгийн шинжилгээний баг (хуучин нэршлээр)-т ирүүлсэн дараах баримт бичгүүдийг архивын 10 боть хадгаламжийн нэгж үүсгэн, хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>-Албан бичиг, өргөдөл, гомдлын тайлан, мэдээ;<br>-Процессын дахин инженерчлэлтэй холбоотой баримт материал;<br>Монгол Улсын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд баригдаж байгаа, баригдаж дууссан болон царцсан барилга, байгууламжийн гүйцэтгэл, ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгааны хүрээнд цугларсан баримтууд багтаж байна. | | |
| 5.2.2 | Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам шинэчлэн боловсруулах | Улсын төсөв | Шинэчлэн боловсруулсан эсэх (Тийм-1, Үгүй-0) | 1 | 1 | 1 | -Газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/40 тоот тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, ЗГХХГ-ын даргын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/64 тоот тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталж,<br>-ЗГХХГ-ын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг боловсруулж Байгууллагын даргын А/155 дугаар тушаалаар батлуулав.<br>-"Албан хаагчдыг зайнаас цахим хэлбэрээр ажиллуулах журам"-ыг боловсруулж, Байгууллагын даргын А/156 дугаар тушаалаар батлуулав.<br>-ЗГХХГ-ын албан хаагчдын сургалтын хөтөлбөр (2025-2029)-ийг Байгууллагын даргын А/157 дугаар тушаалаар батлуулав.<br>-ЗГХХГ-ын удирдах албан тушаалтныг түр эзгүйд үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ албан үүргийг түр орлон гүйцэтгэх хуваарийг Байгууллагын даргын А/184 дүгээр тушаалаар батлуулав. | 100 | 100 |
| 5.2.3 | Монгол хэлний тухай хуулийн | | Төрийн албан хэргийг хос | - | 1 | 1 | Боловсролын сайдын зөвлөмжийн дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлт, үйл ажиллагаанд монгол бичгийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг хангуулж ажиллах | Улсын төсөв | бичгээр хөтлөх тухай зөвлөмжийг мөрдөж ажилласан эсэх (Тийм-1,Үгүй-0) | | | | хэрэглээг нэвтрүүлэх талаар хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Монгол хэлний тухай хуулийн биелэлтийг хангах үүднээс байгууллагын удирдлагын албан бичгийн болон тушаалын бланк захиалан авч ашиглаж эхэлсэн. Байгууллагын удирдлагаас явах 14 албан бичгүүдийг монгол бичгээр давхар үйлдэж ажилласан. | | |
| | | | Монгол бичгээр үйлдсэн албан бичгийн тоо | - | 14 | Гүйцэтгэлээр | 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Монгол хэлний тухай хуулийн биелэлтийг хангах үүднээс байгууллагын удирдлагын албан бичгийн болон тушаалын бланкыг захиалан авч ашиглаж эхэлсэн. Байгууллагын удирдлагаас явах 14 албан бичгийг монгол бичгээр давхар үйлдэж ажилласан. | 100 | 100 |
| 5.2.4 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн харилтай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивлаж, архивд хүлээлгэн өгөх | Улсын төсөв | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (хувь) | - | 100 | 100 | Тайлант хугацаанд 1717 албан бичиг, 612 өргөдөл, гомдол хүлээн авч бүртгэн 100% шилжүүлж ажилласан. /12 сарын 11-ний өдрийн байдлаар | 100 | 100 |
| | | Улсын төсөв | Хугацаандаа архивд хүлээлгэн өгсөн эсэх (Тийм-1, Үгүй-0) | - | 1 | 1 | Архивд баримт хүлээн авах хуваарь гарган батлуулж, зохион байгуулалтын нэгж бүрээс ирсэн бичиг, өргөдөл гомдол, яам, аймаг, нийслэл, төрийн байгууллагуудын 2022-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хяналт шалгалтын баримт бичиг, явуулсан бичиг баримтыг эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлж, эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажил хийж, хадгаламжийн нэгж болгон үдэж хавтаслан, нүүр бичилт хийж, архивд хүлээн авч, баримтын бүртгэл үйлдсэн. Үүнд: 2025 оны 12 дугаар сарын байдлаар **335** байнга хадгалах хадгаламжийн нэгж, түр хадгалах **429** хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах **13** хадгаламжийн нэгж, нийт **777** хадгаламжийн нэгжийг архивд хүлээн аваад байна. Үүнээс гадна Хяналт үнэлгээний Үндэсний хороо татан буугдсантай холбогдуулан 2024 оны **84** хадгаламжийн нэгж, 2025 оны **63** хадгаламжийн нэгж, нийт **147** хадгаламжийн нэгжийг байгууллагын архивдаа хүлээн авч бүртгэл үйлдсэн. Үр дүнгийн шинжилгээний баг (хуучин нэршлээр)-т ирүүлсэн дараах баримт бичгүүдийг архивын 10 боть хадгаламжийн нэгж үүсгэн, хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>- Албан бичиг, өргөдөл, гомдлын тайлан, мэдээ; | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Процессын дахин инженерчлэлтэй холбоотой баримт материал;<br>- Монгол Улсын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд баригдаж байгаа, баригдаж дууссан болон царцсан барилга, байгууламжийн гүйцэтгэл, ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгааны хүрээнд цугларсан баримтууд багтаж байна. | | |
| 5.2.5 | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг сүлжээ, систем, программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | Урсгал төсөв | Хэвийн ажиллагаа, аюулгүй байдал хангагдсан байна (Тийм-1, Үгүй-0) | | 1 | 1 | Байгууллагад хэрэглэгдэж байгаа техник хангамжийн сайжруулалттай холбоотойгоор шинэ компьютер, тоног төхөөрөмж худалдан авч, албан хаагчдад хүлээлгэн өгсөн. Дотоод сүлжээний холболт хийсэн: засгийн газрын II байр "Б" корпусын 57 өрөө тус бүрт дотоод сүлжээний холболт, 1500-2000 метр кабель татах, сувагчлалын болон утасгүй сүлжээний 7 ширхэг WiFi төхөөрөмжүүдийн холболт суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн. Байгууллагын сүлжээний хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангасан. Дотоод удирдлагын Эйбл системийг 140 хэрэглэгчийн эрхийн бүртгэл албан хаагч шинээр бүртгэх, албан тушаалд томилох, хандах эрхийн бүртгэлийг гүйцэтгэсэн. Тушаал, албан бичиг эйбл системээр төлөвлөгдөж тоон гарын үсгээр баталгааждаг болсон.<br>Албаны хэрэглээний программ хангамж Оффис 365 business standard-ийг 140 хэрэглэгчид суурилуулж, эрхийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг гүйцэтгэсэн. Төрийн байгууллагын цахим шуудангийн домэйнийг MS365-т шилжүүлж, windows active directory системийн аюулгүй байдал, хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан. | 100 | 100 |
| 5.2.6 | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг цахим орчинд удирдан явуулах техник, технологийн орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллах | Урсгал төсөв | Арга хэмжээний биелэлтийн хувь | 60 | 100 | 100 | Албан хаагч бүрд MS 365 лиценз эрхтэй хэрэглэгчийн бүртгэл үүсгэж MS teams-д холбож өгөв. Мөн Able эрхийн лиценз сунгаж хэрэглэгчийн тоог 140 болгон албан хаагч бүрд хэрэглэгчийн эрх нээж өгөв. | 100 | 100 |
| 5.2.7 | Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, | Улсын төсөв | Төлөвлөгөөний биелэлт (хувь) | - | 100 | 100 | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг сүлжээ, систем, программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллав. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдлыг хангах | | | | | | | | |
| 5.2.8 | Архивын зориулалтын өрөө, тасалгааг стандартад нийцүүлэн засвар хийх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Гэрээ байгуулах (тоо) | - | 1 | 1 | 2025 оны 4 дүгээр сард архивын зориулалтын өрөө, тасалгааг стандартад нийцүүлэн засвар хийж, баримт хадгалах зориулалтын 8 тасалгаат нягтруулсан шүүгээнд стандартын дагуу хадгаламжийн нэгжийг хадгалж байна. | 100 | 100 |
| 5.2.9 | Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээлэлд хяналт тавих, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагаа, сургалт, хэлэлцүүлэг, орон нутгийн томилолтын мэдээлэл, хэвлэлийн бага хурал зэрэг 78 мэдээ мэдээллүүдийг цахим хуудас /веб сайт, нийгмийн сүлжээний суваг, платформ/-д тогтмол оруулж, хяналт тавьж ажилласан. Өдөр тутмын мэдээ мэдээллийн нийт 62 сайтад утсаар зар тараах, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажиллаад байна.<br>Өдөр тутмын мэдээ мэдээллийн нийт 25 сайтад утсаар зар тараах, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Өдөр тутмын мэдээллээс гадна хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болон зохион байгуулагдах сургалт, хурал болон шуурхай мэдээллийг түгээх, нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангах ажлуудыг зохион байгуулсан.<br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын албан томилолттой холбоотой асуудлаар олон нийтэд тарсан ташаа мэдээллийг залруулах үүднээс Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Өнөрбаяр, Б.Батцэцэг нарыг Zarig.mn, Zuv.mn, isee.mn, tovch.mn, ug.mn, зэрэг сайтууд болон, SBN телевизүүдээр мэдээлэл өгүүлсэн.<br>Zarig.mn, Isee.mn, Өдрийн сонин, 24 цаг, Live tv.mn, зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж 4 удаагийн хэвлэлийн хурал, 2 хэлэлцүүлэг 53 удаагийн уулзалт, хурал, сургалтад оролцож мэдээ бэлтгэсэн.<br>Өдөр тутмын мэдээ мэдээллийн нийт 75 сайтад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгууллаа. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын албан томилолттой холбоотой асуудлаар олон нийтэд тарсан ташаа мэдээллийг залруулах ажлыг зохион байгуулж, Zarig.mn, Zuv.mn, isee.mn, tovch.mn, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ug.mn сайт болон, SBN телевизийн ярилцлагад удирдлагыг оролцууллаа. | 100 | |
| 5.2.10 | Байгууллагын цахим хуудсыг англи хэл болон үндэсний монгол бичгээр давхар хөтлөх | Улсын төсөв | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа, мэдээллийг тогтмол байршуулж байх вэб сайттай байна гэсэн заалтын дагуу Нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ЗГХХГ-ын www.ags.gov.mn вэб сайтыг англи монгол, криллээр хийж гүйцэтгэсэн. Тус сайтад байгууллагын бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүй, ил тод байдал, өдөр тутмын үйл ажиллагаа болон мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна. Мөн Төрийн нэгдсэн портал сайт болох E Mongolia-д мэдээллийг оруулж байна.<br>-2025 оны 5 дугаар сараас 12 дугаар сарын 10 хүртэл 28 мэдээ англиар, 19 мэдээ монгол бичгээр бэлтгэж байршуулсан. Цаашид УИХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсролын яаманд явуулах албан бичгийг монгол бичгээр хүргүүлж байх шийдвэрийг удирдлагын түвшинд гаргасан болно. | 100 | 100 |
| 5.2.11 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хурал, уулзалтыг зохион байгуулалтаар хангаж ажиллах | Улсын төсөв | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Сар шинийн баярын өдрүүдэд ажиллах шуурхай жижүүрийн хуваарийг гаргаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллав.<br>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, холбогдох арга хэмжээнүүдийг зохион байгуулав.<br>Боловсролын сайдын зөвлөмжийн дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлт, үйл ажиллагаанд монгол бичгийн хэрэглээг нэвтрүүлэх талаар хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Байгууллагын даргын тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам" боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж, дотоод журмыг 4 сарын 10-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>-Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хэрэглэх индекс, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, албан хэрэг хөтлөлтийн журмын төсөл боловсруулж, батлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэв.<br>-Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн даргад зөвлөмж, дэмжлэг үзүүлж ажиллав.<br>-Тамгын газраас УИХ, Засгийн газар болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх тайлан мэдээ, байгууллагын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дотоод үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээний нэр төрлийг гаргав. | | |
| 5.2.12 | Нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих, байгууллагын орчны цэвэрлэгээ, тохижилт үйлчилгээ, аюулгүй байдал, дотор цэвэрлэгээ үйлчилгээ, тог цахилгаан, аж ахуйн бусад асуудлыг хэвийн үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Гэрээний биелэлт (хувь) | - | 91-ээс доошгүй | 100 | Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, цэвэрлэгээ, тохижилт, тог цахилгааны асуудал, аж ахуйн бусад асуудлыг тухай бүр Нийтлэг үйлчилгээний газрын эрх бүхий хаагчидтай хамтран тухай бүр шийдвэрлэн ажилласан.<br>Ажлын байранд тухай бүр засварын ажлыг ЗГБНҮГ-ын албан хаагчдаар гүйцэтгүүлж, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.<br>-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр албан хаагчдын дунд Сургалтыг 12 дугаар сарын эхний 7 хоногт хийв.<br>- Гадаад, дотоод томилолтоор ажиллах албан хаагчдад өгөх аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмжийг ХАБЭА-н зөвлөлөөс баталж, 28 албан хаагчид зөвлөмжийг танилцуулж ажилласан. | 100 | 100 |
| 5.2.13 | "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" боловсруулан батлуулах, албан хаагчдад танилцуулах | Улсын төсөв | Төлөвлөгөө батлагдаж, албан хаагчдад танилцуулагдсан байна (Тийм-1, Үгүй-0) | - | - | 1 | 2025.10.29-ны өдрийн 02/750 дугаар албан бичгийн хавсралтаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, хүргүүлсэн. | 100 | 100 |
| 5.2.14 | Байгууллагын оффисын орчимд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэд бүтэц бүрдүүлэх судалгаа хийх | Улсын төсөв | Судалгааны тайлан (тоо) | - | - | 1 | Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Засгийн газрын байрнуудын нэгдсэн захиргааны дэмжлэгтэйгээр Засгийн газрын II байрны "Б" хэсгийн гадна нэвтрэх хаалганд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шатыг хийж байршуулсан. | 100 | 100 |
| 5.2.15 | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам, албан хэргийн нэрийн жагсаалт, байгууллагын | Улсын төсөв | Батлагдсан журам (тоо) | - | 1 | 1 | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн журмын төслийг боловсруулж, хянуулах шатанд байна. | 100 | 80 |
| | | | Албан хэргийн нэрийн батлагдсан жагсаалт (тоо) | - | 1 | 1 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төслийг боловсруулж, Архивын ерөнхий газрын улсын байцаагчаар хянуулан, байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хэрэг хөтлөлтийн индексийг шинэчлэн батлуулах, мөрдүүлж ажиллах | | | | | | комиссын хурлаар оруулан хэлэлцэж батлуулахад бэлэн болоод байна. | | |
| | | | Индекс /батлагдсан/ (Тоо) | - | 1 | 1 | Зохион байгуулалтын бүтцийн нэгжид олгох, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индекс болон албан бичигт гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэр, индекс батлуулах тушаалын төслийг боловсруулж газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100 | 100 |
| 5.2.16 | Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | Улсын төсөв | Өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | **1.**ЗГХХГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/158 дугаар тушаалаар байгуулсан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулах ажлын дэд хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2024 оны 309 дүгээр тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулан ажиллаж, 01 дүгээр сарын 25-ыг хүртэл Төрийн албаны тухай хуулийн 12 бүлэг, 37 зүйл, 145 хэсгийн хүрээнд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, дүгнэлтийг бичиж боловсруулан нэгдсэн тайланг ЗГХЭГ-ын дэргэдэх Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>**2.**ЗГХХГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан "Төлөвлөлт, мониторинг, үнэлгээний чиглэлээр зохион байгуулах богино хугацааны цогц сургалт"-ыг нэгдсэн удирдлагаар хангах болон зохион байгуулж ажиллах Ажлын хэсэгт ажиллаж, төлөвлөгөөний дагуу богино хугацааны цогц сургалтад оролцох хүсэлт ирүүлсэн албан хаагчдаас ирүүлсэн эссэг шалгаруулах, үнэлэх ажлыг удирдамжийн дагуу хэрэгжүүлж ажилласан.<br>**3.**Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг "Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах шуурхай штабыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 150 дугаар захирамжаар байгуулсан. Уг шуурхай штабын эхний 5 удаагийн хуралдаанаар өгөгдсөн нийт 6 чиглэлийн 85 үүрэг даалгаварт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгөгдсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4.Салбарын асуудлыг шийдвэрлэх, ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний тухай хууль, эрх зүйн орчин талаас нь саналаа 2025 оны 5-р сарын 29-ний өдөр О.Саранчулуун гишүүнд хүргүүлэн, дэмжлэг үзүүлсэн. Дэд ажлын хэсэг хуралдаж олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан санал дүгнэлтийг хэлэлцэж өөрсдийн саналыг УИХ-ын гишүүн О.Саранчулуун гишүүнд хүргүүлсэн. Ажлын хэсгийн гишүүдийн хамтаар О.Саранчулуун гишүүн "Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх тухай" хуулийн төслийг боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 29-ны өдөр d.parliament.mn сайтад байршуулаад байна.<br>5."Гадаадын арбитр болон гадаад улсын шүүхэд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүссэн тохиолдолд баримтлах журам"-д өөрчлөлт оруулах талаар нэмэлт, өөрчлөлтийн төсөл, сайдын хэлэх үг, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга зэргийг бэлтгэн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.3 Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төсөв санхүүгийн удирдлага, дотоод хяналтыг хэрэгжүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | - | 100 | **Энэ зорилтын хүрээнд нийт 14 арга хэмжээ төлөвлөсөн ба хэрэгжилтийн дундаж хувь 100% байна.** | **100** | |
| 5.3.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах | Улсын төсөв | Мэдээний тоо | 171 | 171 | 171 | 109 мэдээг хугацаандаа мэдээлсэн. Үлдсэн мэдээ нь мэдээлэх хугацаа болоогүй. | 100 | 100 |
| 5.3.2 | Байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаар иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагаа, сургалт, хэлэлцүүлэг, орон нутгийн томилолтын мэдээлэл, хэвлэлийн бага хурал зэрэг 78 мэдээ мэдээллүүдийг цахим хуудас /веб сайт, нийгмийн сүлжээний суваг, платформ/-д тогтмол оруулж, хяналт тавьж ажилласан. Өдөр тутмын мэдээ мэдээллийн нийт 25 сайтад утсаар зар тараах, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажиллаад байна. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3.3 | Өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодох ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал, жилийн санхүүгийн тайланд тэнцэлд тусгах | Улсын төсөв | Бүртгэл хийсэн байдал (тоо) | 2 | 2 | 2 | 2024 оны жилийн эцсийн хөрөнгө тооллогын комисс хөрөнгийн тооллого хийн дуусгасан. Үндсэн хөрөнгө болон тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлж бар код нааж тооллого хийн ажилласан байна. Нийт 1631 ширхэг үндсэн хөрөнгө, 369 ширхэг бараа материал бүртгэж ажилласан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 320 ширхэг бараа материалын худалдан авалт бүрийг анхан шатны баримтаар баталгаажуулан бүртгэн авч ажиллаж байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 226 төрлийн 18023 тоо ширхэг бүхий бараа материалын худалдан авалт бүрийг анхан шатны баримтаар баталгаажуулан бүртгэн авч ажиллаж байна. Мөн 2025 оны үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийж байна. 12 сарын 01-ний байдлаар тооллогын үр дүнг танилцуулсан. | 100 | 100 |
| 5.3.4 | Төсвийн шууд захирагчийн 2026 оны хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах | Улсын төсөв | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө биелэлтийн хувь | 100 | 100 | 100 | Төсвийн шууд захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаар тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөнд шууд худалдан авах 4 төсөл арга хэмжээг 51.7 сая, ерөнхий гэрээний аргаар худалдан авах 6 төсөл арга хэмжээг 223.7,0 сая, нийт 10 төсөл, арга хэмжээг 275,4 сая төгрөгөөр төлөвлөсөн. 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/149 дугаар тушаалаар Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталсан. Түүний дагуу 25 гэрээний төлбөр гүйлгээг хийсэн.<br>Төсвийн шууд захирагчийн 2026 оны хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулахаар ажиллаж байна. Төсвийн шууд захирагчийн 2026 оны хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хүргүүлсэн. | 100 | 100 |
| 5.3.5 | Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх | Улсын төсөв | Тайлан, мэдээний тоо | 4 | 2 | 4 | Эхний хагас жилийн байдлаар хагас жилийн санхүүгийн тайлан, холбогдох бусад тайлан мэдээг гаргасан.<br>3-р улирлын байдлаар татварт 3 тайлан, сараар 11 мэдээ тайлан гаргаж зохих байгууллагуудад илгээсэн байна. | 100 | 100 |
| 5.3.6 | Үндэсний Аудитын газар болон бусад байгууллагаас Засгийн газрын | Улсын төсөв | Зөвлөмжийн биелэлт (хувь) | - | - | 100 | 2025 онд Үндэсний Аудитын газраас 2024 оны Санхүүгийн үйл ажиллагаанд 6 албан шаардлага, 1 зөвлөмж өгсний дагуу биелэлтийг гаргуулан удирдлагад танилцуулсан. Мөн “Засгийн газрын ерийн удирдлагын 2023-2025 оны | 90 | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих | | | | | | стратегийн баримт бичгийн хэрэгжилт" сэдэвт аудитын тайлангийн мөрөөр ҮМГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьсан. | | |
| 5.3.7 | Байгууллага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих, тайлагнах | Улсын төсөв | Зөвлөмжийн хэрэгжилт (хувь) | - | | 100 | Байгууллагын дотоод өргөдөл гомдол, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, нийгмийн баталгааны хөтөлбөр зэрэг дотоод журамд заагдсан асуудал дээр хяналт тавин тус тусад нь тайлан мэдээ төсвийн ерөнхийлөн захирагч болон удирдлагын зөвлөлийн хурлаар давхардсан тоогоор 16 тайлан мэдээг гаргаж танилцуулсан. | 100 | 100 |
| 5.3.8 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Улсын төсөв | Аудит хийсэн тайлан (тоо) | - | 1 | 1 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69,1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,2, Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан " Дотоод аудитын дүрэм"-д тусгагдсан эрх, үүргийн хүрээнд 2025 оны 04дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрийн хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ. Аудитаар 6 зөрчлийг илрүүлж хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. | 100 | 100 |
| 5.3.9 | Байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих | Улсын төсөв | Шийдвэрлэлийн хувь | - | 100 | 100 | 1.2025 оны 01-р улирлын Бүтцийн нэгжийн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт хийж тайлан бичиж Нэгжийн дарга, Газрын даргад тус тус танилцуулсан. Дотоод хяналтын хамрах хугацаанд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын бүтцийн нэгжүүдээс 48 өргөдөл, санал хүсэлт удирдлагаас Тамгын газарт хуваарилагдсан байна.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдал (40) **83.3** хувь байна.<br>2. 2025 оны эхний хагас жилийн Бүтцийн нэгжийн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт хийж тайлан бичиж Нэгжийн дарга, Газрын даргад тус тус танилцуулсан. Дотоод хяналтын хамрах хугацаанд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын бүтцийн нэгжүүдээс 99 өргөдөл, санал хүсэлт Тамгын газарт хуваарилагдсан байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал 51.5 хувь, хариу өгөхөд дунджаар 12.1 хоногийн хугацаа зарцуулж байна. | 100 | 70 |
| 5.3.10 | Байгууллагад болон Иргэд олон нийттэй харилцах төв 11-11-ээс | Улсын төсөв | | | | | 1.2025 оны 1-р улирлын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэлтэд хяналт хийсэн тайланг Нэгжийн дарга, Газрын даргад танилцуулсан. Дотоод хяналтын хамрах хугацаанд Газруудад нийт 116 | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шилжин ирсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих | | Шийдвэрлэлтийн хувь | - | 100 | 100 | өргөдөл, гомдол удирдлагаас шилжин ирснээс нийт өргөдөл, гомдлын 97 хувийг Хяналт шалгалтын газарт, 3 хувь нь Дотоод хяналт, аудитын газарт хуваарилагдсан байна. Тайлант хугацаанд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлсэн нийт 116 өргөдөл, гомдлыг 30 албан хаагчид хуваарилсан байх ба нэг албан хаагчид дунджаар 4 өргөдөл, гомдол ногдож байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэж байгаа дундаж хугацаа **12.4** хоног байна.<br>2.2025 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэлтэд хяналт хийсэн тайланг Нэгжийн дарга, Газрын даргад танилцуулсан. Дотоод хяналтын хамрах хугацаанд Газруудад нийт 202 өргөдөл, гомдол удирдлагаас шилжин ирсэн байна. Ирүүлсэн өргөдөл, санал гомдлын шийдвэрлэлтийн байдал **90.1** хувь буюу 182 өргөдөл, гомдол, хариуг өгөхөд дунджаар 13 хоногийн хугацаа зарцуулж байна. | | |
| 5.3.11 | Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг бүртгэж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, гэрээг дүгнэх | Улсын төсөв | Батлагдсан гэрээний тоо | - | | 145 | Тайлант хугацаанд хуулийн этгээд, иргэнтэй байгуулсан 99 гэрээг бүртгэж дугаар олгон, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, дүгнэж ажилласан. | 100 | 68 |
| 5.3.12 | Засгийн газрын хуралдаан, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, ХҮҮХ-ны даргын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих | Улсын төсөв | Хэрэгжилтэд хяналт хийсэн тоо | - | 4 | 4 | 1.2025 оны 1-р улирлын байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Засгийн газрын 17 тогтоол, 29 тэмдэглэл, 6 албан даалгавар нийт 36 шийдвэрийн 52 заалт байна. Хууль тогтоомж, тогтоолын 36 шийдвэрийн 52 заалтаас "Хэрэгжсэн" 26, "Хэрэгжиж буй" 10, "Хэрэгжээгүй" 3, "Хугацаа болоогүй" 12, "Чиг үүрэгт хамааралгүй" 1 заалт байна. Бүтцийн нэгжүүд цаашид анхаарах шаардлагатай асуудлыг тэмдэглэн Газрын дарга болон удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.<br>2.2025 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Засгийн газрын 17 тогтоол, 29 тэмдэглэл, 6 албан даалгавар нийт 36 шийдвэрийн 52 заалт байна. Хууль тогтоомж, тогтоолын 36 шийдвэрийн 52 заалтаас "Хэрэгжсэн" 26, "Хэрэгжиж буй" 13, "Хугацаа болоогүй" 12, "Чиг үүрэгт хамааралгүй" **1** заалт байна. | 100 | 100 |
| 5.3.13 | Байгууллагын үйл ажиллагаатай | | Хяналт, шинжилгээ | - | 2 | 4 | -Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны биелэлтэд улирал тутамд ХШҮ хийж зөвлөмж өгсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдсон хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн явц, байгууллагын болон зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Улсын төсөв | үнэлгээний давтамж (тоо) | | | | -Байгууллагын зохион байгуулалтын бүтцийн 7 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны биелэлтэд улирал тутамд ХШҮ хийж зөвлөмж өгсөн.<br><br>-Нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны улирлын биелэлтэд улирал тутамд хяналт хийж зөвлөмж өгсөн.<br>-Шилэн дансны 3 улирлын хэрэгжилтийг шалгаж тайланг бичиж газрын даргад танилцуулсан. Мөн 11 сард шууд худалдан авалтаар гэрээ байгуулсан газруудын 5,0 саяас дээш үнийн дүн бүхий мэдээллийг шилэн дансны мэдээллээс жагсаалтыг гаргасан.<br>-ЗГХХГ-ын Санхүүгийн 2 улирлын үйл ажиллагаанд аудит хийж тайланг удирдлагуудад танилцуулж, Үндэсний аудитын газраас ирсэн явцын аудитын ажлын хэсэгт дотоод аудит хийсэн тайлан болон судалгааг гаргаж өгсөн, мөн Дотоод албан бичгээр зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг гаргуулж авсан.<br>-2025 онд Үндэсний Аудитын газраас 2024 оны Санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан 09-р сарын 01-нд ҮАГ-ын сайтад биелэлтийг бичиж албан бичгээр хэрэгжилтийг явуулсан болно. Мөн " Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт" сэдэвт аудитын тайлангийн мөрөөр ҮМГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьсан.<br>-2025 оны 1-р улирлын байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Засгийн газрын 17 тогтоол, 29 тэмдэглэл, 6 албан даалгавар нийт 36 шийдвэрийн 52 заалт байна. Хууль тогтоомж, тогтоолын 36 шийдвэрийн 52 заалтаас "Хэрэгжсэн" 26, "Хэрэгжиж буй" 10, "Хэрэгжээгүй" 3, "Хугацаа болоогүй" 12, "Чиг үүрэгт хамааралгүй" 1 заалт байна. Бүтцийн нэгжүүд цаашид анхаарах шаардлагатай асуудлыг тэмдэглэн Газрын даргад танилцуулсан.<br><br>-2025 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Засгийн газрын 17 тогтоол, 29 тэмдэглэл, 6 албан даалгавар нийт 36 шийдвэрийн 52 заалт байна. Хууль тогтоомж, тогтоолын 36 шийдвэрийн 52 заалтаас "Хэрэгжсэн" 26, "Хэрэгжиж буй" 12, "Хэрэгжээгүй" 1 "Хугацаа болоогүй" 12, "Чиг үүрэгт хамааралгүй" 1 заалт байна.<br>-2025 оны 3-р улирлын байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах үүрэг даалгаврын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтийн тайланд ДХАГ-с хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Бүтцийн нэгжүүд цаашид анхаарах шаардлагатай асуудлыг тэмдэглэн Удирдах зөвлөл болон Газрын даргад танилцуулж, Үнэлгээний систем new.unegee.gov.mn сайтад тухай бүр тайлагнасан. Үүнд:<br>1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт<br>2. албан даалгаврын 8 дугаар сарын хэрэгжилт<br>3. албан даалгаврын 9 дүгээр сарын хэрэгжилт<br>хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны 3 дугаар улирлын хэрэгжилт<br>-Засгийн газрын Хяналт-шинжилгээ, мэдээллийн цахим санд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх хугацаа болоогүй тул хүлээгдэж байна. | | |
| 5.3.14 | Байгууллагын архив, албан хэргийг хөтлөх, дотоод үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих | Улсын төсөв | Биелэлтийн хувь | - | - | 100 | -Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд 2025 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс эхлэн хяналт тавьж ажиллаж байна.<br>-2025 оны 1-р улирлын байдлаар Даргын А тушаал 50, Б тушаал 52 батлагдан гарсан. Тушаалын биелэлтэд хэрэгжилтэд хяналт хийж, цаашид авах арга хэмжээний талаар тайлан бичиж Нэгжийн дарга, Газрын даргад танилцуулсан.<br>-2025 оны эхний хагас жилийн өссөн дүнгээр Даргын А тушаал 95, Б тушаал 91 батлагдан гарсан. А тушаал хэрэгжсэн 75, хугацаа болоогүй 14, хэрэгжээгүй 5, хүчингүй 1, Б тушаал хэрэгжсэн 1, хүчингүй 1 байна. Тушаалын биелэлтэд хэрэгжилтэд хяналт хийж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж бичиж Нэгжийн болон Газрын даргад танилцуулсан.<br>-2025 оны 3-р улирлын байдлаар Даргын А тушаал 21, Б тушаал 92 батлагдан гарсан. Б тушаал 100 хувийн хэрэгжилттэй. Нийт 92 тушаалын биелэлтэд хэрэгжилтэд хяналт хийж, цаашид авах арга хэмжээний талаар тайлан бичиж Нэгжийн дарга болон Газрын даргад танилцуулсан.<br>-2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар А, Б тушаалын хэрэгжилтэд хяналт хийсэн тайланг одоогоор Тамгын газар дотоод сүлжээнд гүйцэт оруулаагүй байгаа тул хүлээгдэж байна.<br>-Байгууллагын даргын тушаалаар батлагдсан нийт 17 ажлын хэсгийн явц, хэрэгжилтэд хяналт тавьсан. | 100 | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Байгууллагын дотоод өргөдөл гомдол, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, нийгмийн баталгааны хөтөлбөр зэрэг дотоод журамд заагдсан асуудал дээр хяналт тавин тус тусад нь тайлан мэдээ төсвийн ерөнхийлөн захирагч болон удирдлагын зөвлөлийн хурлаар давхардсан тоогоор 16 тайлан мэдээг гаргаж танилцуулсан. Мөн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллан, дотоод журам шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт санал хүргүүлж ажиллаа.<br>-ЗГХХГ-ын 2025 оны "Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"г боловсруулан 2025.02.20-ны өдөр ЗГХХГ-ын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалтуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.<br>-ЗГХХГ сургалтын хөтөлбөрийг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан тул хөлбөрт хяналт хийгдээгүй. Өссөн дүнгээр сургалтын үйл ажиллагааны тайланг нэгтгэн хянана.<br>-Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу 2025 оны төлөвлөгөө гаргасан боловч байгууллагын удирдлагаар батлуулаагүй байгаа тул батлуулах шаардлагатай байна. Төлөвлөгөөний төсөлд тусгасан нийт арга хэмжээнээс 3 арга хэмжээ одоогоор зорилтдоо хүрээгүй байна.<br>-2025 оны Байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтэд улирал тутам тайлан гаргаж удирдлагад танилцуулсан. Дотоод хяналтын хамрагдах хугацаанд Нэгжүүдийн хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг авч үзвэл байгууллагын дунджаар 90,97 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>-Албан хаагчдын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтын тайланг able цахим системийн бүртгэлийн мэдээллийг ашиглан 6 удаагийн сар улирлын давтамжтайгаар гаргаж удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох бүтцийн нэгжийн газруудад дотоод албан бичгээр дүгнэлт зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.<br>-Дотоод хяналт, аудитын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан 01 дүгээр Удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл байгууллагын хүний нөөцийн асуудлыг сайжруулах зорилгоор Тамгын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтын хүрээнд 1. Байгууллагын нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт 2.Гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ хийсэн эсэх, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайланг гаргуулж авсан эсэх дээр дүгнэлт, зөвлөмж гаргаж газрын дарга болон холбогдох газарт танилцуулсан.<br>-2025 онд улирал тутамд бүтцийн нэгжийн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт хийж тайлан бичиж Нэгжийн дарга, Газрын даргад тус тус танилцуулсан. Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал 51.5 хувь, хариу өгөхөд дунджаар 12.1 хоногийн хугацаа зарцуулж байна.<br>-2025 оны 4-р улирлын байдлаар өссөн дүнгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэлтэд хяналт хийсэн тайланг Нэгжийн дарга, Газрын даргад танилцуулсан. Дотоод хяналтын хамрах хугацаанд Газруудад нийт 202 өргөдөл, гомдол удирдлагаас шилжин ирсэн байна. Ирүүлсэн өргөдөл, санал гомдлын шийдвэрлэлтийн байдал **90.1** хувь буюу 182 өргөдөл, гомдол, хариуг өгөхөд дунджаар 13 хоногийн хугацаа зарцуулж байна.<br>-Иргэн Э.Төмөрбат, Г.Ганболд, Ю.Батхүү болон Боловсролын давалгаа ТББ-аас, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас Хяналт шалгалттай холбогдуулан гомдол гаргасан. Гомдлыг зохих журмын дагуу хянан үзэж хариуг өгсөн. | | |

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД .................................................... Ж.ЭНХБАЯР

*Тэмдэг* *(гарын үсэг)*

*2025 он 12 дугаар сарын .... -ны өдөр*

**ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАСАН:**

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА .................................................... Б.БАТЦЭЦЭГ

*Тэмдэг* *(гарын үсэг)*

*2025 он 12 дугаар сарын 19 -ны өдөр*